



**ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН 2026 ОНЫ
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ**



АГУУЛГА

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлын зарлал	03
Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн тогтоол	04
Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлын дэг	06
Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлууд:	
1. ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;	07
2. ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;	60
3. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан;	66
4. ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;	69
5. Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;	73
6. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай.	89
Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслүүд	93
Тооллогын комиссын бүрэлдэхүүн	101
Саналын хуудасны загварууд	103

ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАРЛАЛ

ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-21 дүгээр тогтоолын дагуу Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.4 дэх хэсгийг үндэслэн, хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг үүгээр зарлаж байна.

Компанийн нэр, байршил: ХасБанк ХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72

Хурал болох өдөр, цаг, газар: 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж -19 хаягт байрлах Шангри-Ла зочид буудлын Их танхимд хосолсон (танхим болон цахим) хэлбэрээр зохион байгуулагдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Танилцуулах асуудал:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан.

- Шийдвэрлэх асуудал:

1. ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;
3. ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;
4. Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
5. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай.

Хувьцаа эзэмшигч та хурлын материалуудтай танилцах бол 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн банкны цахим хуудаст (www.xacbank.mn) болон ажлын өдрүүдэд өөрт ойр үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хандана уу.

Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч нь өөрийн саналыг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10:00 цагаас эхлэн хувьцаа эзэмшигчдийн хурал дуустал хугацаанд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахимаар өгөх боломжтой.

Холбоо барих:

Утас: +(976)-8508-1888

Цахим шуудангийн хаяг: investor-relations@xacbank.mn

Ажиллах цагийн хуваарь: ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2026 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2026 оны 03 сарын 20 өдөр

№ R-2026-21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ТУЗ нь Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("ХЭЭХ")-ыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулах үүрэгтэй ба ТУЗ дараах шийдвэрийг батлахыг дэмжсэн болохыг тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны ХЭЭХ-ыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпын гудамж -19 хаягт байрлах Шангри-Ла зочид буудлын Их танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлыг танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулсугай.
3. Банкны дүрмийн 8.9 дэх хэсэгт заасны дагуу ХЭЭХ-ын даргаар Банкны ТУЗ-ийн дарга Санжай Гүптаг зарласугай.
4. ХЭЭХ-ыг Зохион байгуулах комиссын даргаар Банкны Ерөнхий аудитор Б.Биндэрьяг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
5. ХЭЭХ-ыг зарлан хуралдуулах тухай мэдэгдлийг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-д хүргүүлэхийг ТУЗ-ийн ажлын албанд даалгасугай.
6. ХЭЭХ-ыг хуралдуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны веб сайт (www.xacbank.mn), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

7. ХЭЭХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр байхаар тогтоосугай.
8. ХЭЭХ-аар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, хурлын танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбогдох баримт бичгийг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
9. ХЭЭХ-ын хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, ХЭЭХ-ын хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, ХЭЭХ-ын Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, ХЭЭХ-ын дэгийг 4 дүгээр хавсралтаар, ХЭЭХ-ын саналын хуудсуудыг 5 болон 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
10. Санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн урьдчилсан саналыг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10:00 цагаас 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт ХЭЭХ эхлэх хүртэл хугацаанд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан гагцхүү цахимаар хүлээн авсугай.
11. Хувьцаа эзэмшигчдээс урьдчилан өгсөн саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал дээр өгсөн саналтай нэгтгэн, тооллогын дүнд оруулан тооцохыг Тооллогын комисст даалгасугай.
12. ХЭЭХ-аас гаргасан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, мөн холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-нд хүргүүлэхийг ТУЗ-ийн ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Цаг	№	Үйл ажиллагаа	Хариуцах ажилтан
8:30-9:00	1	Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл	Тооллогын комисс
9:00-хурал дуусах хүртэл	2	Хурлын ирцийн танилцуулга	Тооллогын комисс
	3	Хурлын үйл ажиллагааны нээлт	Хурлын дарга
	4	Хурлын дэгийн танилцуулга	Гүйцэтгэх захирал
	5	ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлан, түүний талаарх ТУЗ-ийн дүгнэлт	Гүйцэтгэх захирал
	6	Асуулт, хариулт	
	7	ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, түүний талаарх ТУЗ-ийн дүгнэлт	Санхүү хариуцсан захирал
	8	Асуулт, хариулт	
	9	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан	ТУЗ-ийн хараат бус гишүүд
	10	Асуулт, хариулт	
	11	ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга	Гүйцэтгэх захирал
	12	Асуулт, хариулт	
	13	Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалтын танилцуулга	Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД
	14	Асуулт, хариулт	
	15	ТУЗ-ийн 2026 оны төсвийн танилцуулга	Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД
	16	Асуулт, хариулт	
	17	Санал хураалтын хаалт	Хурлын дарга
	18	Завсарлага – санал тоолох	Тооллогын комисс
	19	Санал хураалтын нэгдсэн дүнг танилцуулах	Тооллогын комисс
	20	Хурлыг хаах	Хурлын дарга

Санал хураалт/тоолох зарчим: Саналаа цахимаар өгөхөөр төлөвлөж буй хувьцаа эзэмшигч нь 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10:00 цагаас эхлэн хувьцаа эзэмшигчдийн хурал дуустал хугацаанд саналаа өгөх боломжтой. Хуралд биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигч нь санал хураах асуудал тус бүрээр дэгт заасан хугацаанд саналаа өгнө.

Хориглох зүйл: Хувьцаа эзэмшигч нь санал хэлэх, асуулт тавих дараалал зөрчих, хэлэлцэх асуудалд хамааралгүй асуудал дэвшүүлэх болон үймээн дэгдээх зэргээр хурлын дэг зөрчихийг хориглоно.



Хурлаар шийдвэрлэх нэгдүгээр асуудал:

ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх
ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай





ХАСБАНК

ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

Агуулга

Онцлох үйл явдал

Цахим шилжилт

Санхүүгийн үзүүлэлтүүд

Монголбанкнаас тогтоосон зохистой
харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Компанийн засаглал



Онцлох үйл явдал

2025 оны жилийн эцэс



147 сая ам.долларын синдикат зээлийн гэрээ байгуулав

ХасБанк Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-тай 147 сая ам.долларын синдикат зээлийн гэрээнд гарын үсэг зурж ЕСБХБ-аас Монгол Улсын банкны салбарт хийж буй хамгийн өндөр дүнтэй санхүүжилт боллоо. Оролцогчоор Allianz Global Investors, FMO, ILX, Германы АКА Банк болон Invest in Visions гэсэн байгууллагууд оролцжээ.




Хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг 20%-аас хэтрүүлэхгүй байх хуулийн шаардлагыг бүрэн хангалаа

Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанканд нэгтгэх үйл явц бүрэн хэрэгжиж дууслаа. Ингэснээр ХасБанк “Банкны тухай хууль”-д заасан нэг хувьцаа эзэмшигчийн төвлөрөл 20%-иас хэтрэхгүй байх гол шаардлагыг хангасан системийн хэмжээний цорын ганц банк болж байна.


ЗАЛУУ БИЗНЕС ЭРХЛЭГЧИД ЗОРИУЛСАН ЗЭЭЛ

ХасБанк 35 хүртэлх насны залуу бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөтгөж, ашиг орлогоо нэмэгдүүлэн өгсөх шатанд нь хүч нэмэхийг зорьж, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг нь шийдэхэд зориулж “Залуу бизнес эрхлэгчийн зээл”-ийг санал болгож байна.



Шатлан буурах хүү

Зээлийн хугацааг 3 тэнцүү хувааж, хугацаа бүрд хүү 0.5 нэгжээр шатлан буурна.



Барьцааны хөнгөлөлт

50 сая хүртэл барьцаагүй, 100 сая хүртэл үл хөдлөх хөрөнгө шаардахгүй. 3-дагч этгээдийн барьцааг зөвшөөрнө.



SplendorPlus

Төлбөр тооцонд төгс нийцсэн, нэр хүндийг илтгэх Platinum card + Priority pass



Онцлох үйл явдал

2025 оны жилийн эцэс

Global Finance

Global Finance сэтгүүлээс ХасБанкийг МУ-ын шилдэг банкаар шалгаруулж, шагналыг 10-р сарын 18-нд Вашингтон хотод гардууллаа.

Онцлох ТоС Банк

ХасБанк 2025 оны “Онцлох ТоС Банк”-аар дахин шалгарлаа. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага болон Уур амьсгалын эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж, өөрийн зээл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой хүлэмжийн хийн (CO₂) ялгарлыг тооцоолж, олон улсын PCAF (Partnership for Carbon Accounting Financials) санаачилгад тайлангаа амжилттай нийтлэн, “Тайлагнасан” гэсэн статусыг авсан нь 2025 оны онцлох үйл явдал байлаа.




MOODY'S

B1 Stable

Олон улсын үнэлгээний Moody's Ratings агентлаг ХасБанкны урт хугацааны зээлжих зэрэглэлийг B2-оос B1 (тогтвортой) болгон нэг шат ахиуллаа. МУ-ын Засгийн Газрын зээлжих зэрэглэл ахисан болон ХасБанкны санхүүгийн үзүүлэлт тогтвортой сайжирсан зэрэг нь ХасБанкны урт хугацааны зээлжих зэрэглэл (Deposit rating, Issuer rating)-ийг ахиулах нөхцөл болсныг Moody's дурдаад, ийнхүү ахиулсан Монгол Улсын хоёр банкны нэг нь ХасБанк болсон юм.

FitchRatings

B+ Stable

Fitch Ratings нь ХасBank-ийн Урт хугацааны үнэт цаас гаргагчийн зээлийн зэрэглэл (IDR)-ийг “B+” түвшинд, Тогтвортой төлөвтэй хэвээр баталгаажууллаа. Энэ нь тус банкны активын чанар болон Монгол улсын үйл ажиллагааны орчны тогтвортой төлөвийг илэрхийлж байна.



Teen card

Шинэ картууд гарлаа

ХасБанк хүүхэд, өсвөр үеийнхний санхүүгийн боловсрол, өдөр тутмын санхүүгийн хэрэглээг дэмжих зорилготой ХасTeen картыхаа шинэчлэгдсэн, өвөрмөц загваруудыг танилцууллаа. Карт захиалснаар ХасTeen апп-тай холбогдож, картын үлдэгдлээ шалгах, шилжүүлэг хийх зэрэг өдөр тутмын санхүүгийн хэрэглээгээ хүүхэд өөрөө бие даан удирдах боломжтой.



150 сая ам.долларын синдикат зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа

ХасБанк Нидерландын Хөгжлийн Банкнаас 150 сая ам.долларын санхүүжилт авах синдикат зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа. Уг санхүүжилт нь бүхэлдээ бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжихэд зориулагдах бөгөөд залуу болон эмэгтэй бизнес эрхлэгчид, мөн хөдөө аж ахуйн салбарын бизнесүүдэд түлхүү чиглэх бол үлдсэн хэсэг нь байгаль орчинд ээлтэй, ногоон бизнес, мөн ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулагдах юм.

Цахим шилжилт

2025 оны жилийн эцэс

InstaPay

InstaPay цахим хэтэвчийг зах зээлд амжилттай нэвтрүүлж, "Weekly Boost", "Наадмын амралтаа InstaPay-тэй", "99% Anywhere" аянуудыг зарлаж өдөр тутмын худалдан авалтын төлбөрөө InstaPay-р хийсэн харилцагчдадаа Reward 🙌 бэлэглэлээ. Ингэснээр идэвхтэй хэрэглэгчийн тоо 25,350-д хүрч, нийт хандалтын тоо 98,910 боллоо.



ХасTeen+

7-17 насныханд зориулсан ХасTeen+ аппликейшний эхний хувилбарыг 5-р сард зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Тус аппликейш нь өөрийн давтагдашгүй өнгө төрхийг бүтээж, өдөр тутамын санхүүгээ сонирхолтой, хялбар байдлаар бүрэн удирдах боломжийг хүүхэд залууст олгох юм.



Дижитал шилжилт:



Ebarimt хялбар бүртгэл

ХасБанкны картаар хийсэн худалдан авалтын төлбөрийн баримт Ebarimt-ын системд автоматаар бүргэгддэг боллоо.



IBAN лавлах үйлчилгээ

IBAN лавлах үйлчилгээ шинэчлэгдсэнээр Дижитал банк, InstaXPay, ХасTeen+ app-уудаар гүйлгээ хийхэд илүү хялбар боллоо.



UnionPay картаа

Alipay болон Wechat app-уудад холбон, худалдан авалт, төлбөр тооцоогоо шимтгэлгүй хийх боломжтой боллоо.

Санхүүгийн үр дүн

2025 оны жилийн эцэс

Цэвэр ашиг	ROE	ХАС (хувьцааны ханш)	EPS	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
₮172.6 тэрбум	21.8%	₮963.9	₮164.1	20.1%	37.6%

Ашигт ажиллагаа

- ХасБанк 2025 онд нийт 172.6 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. 2025 онд Банкны зээлийн багцын өсөлтийг даган хүүгийн орлого өссөн боловч төв банкны своп хэлцлийн хүүгийн зардал нэмэгдсэн, мөн заавал байлгах нөөцийн хэмжээг нэмэгдүүлсэн зэрэг нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн байна. Мөн түүнчлэн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан банкны чанаргүй зээлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад өссөн нь сангийн зардлыг нэмэгдүүлсэн байна.
- 2025 оны байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 21.8 хувь, нэгж хувьцаанд ногдох ашиг буюу EPS 164.1 төгрөг байна.

Баланс

- 2025 онд нийт зээлийн багц 4,183 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 13.1 хувиар өслөө.
- Иргэдийн банкны зээлийн багц оны эхнээс 4.8 хувиар өсөж 2,710 тэрбум төгрөгт хүрэхэд хэрэглээний болон бичил, ЖДБ зээлийн өсөлт нөлөөлжээ.
- ХасЛизингийн санхүүгийн түрээс болон зээлийн багц 659 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 41.1 хувь. 2025 онд шинэ автомашины зээлийн үлдэгдэл оны эхнээс 43.9 хувиар өссөн бол дугаартай автомашины зээлийн үлдэгдэл оны эхнээс 50.6 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд ХасMortgage үйлчилгээг өргөжүүлсний үр дүнд ХасЛизингийн багц дахь орон сууцны зээлийн үлдэгдэл оны эхнээс 81.2 хувиар өссөн байна.
- Байгууллагын банкны зээлийн багц оны эхнээс 26.6 хувиар өсөж 814 тэрбумд төгрөгт хүрлээ.
- Чанаргүй зээлийн харьцаа 2.5 хувь байгаа нь банкны салбарын тэргүүлэх үзүүлэлт юм.
- Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ оны эхнээс 9.4 хувиар өсөж 3,749 тэрбум төгрөгт хүрлээ. 2025 онд ХасБанк нийт 263.2 сая ам.доллар болон 33.2 тэрбум төгрөгийн гадаад эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн бөгөөд үр дүнд нийт гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 548 сая ам.долларт хүрч оны эхнээс 22 хувиар өссөн байна.

Харьцаа үзүүлэлт


- 2025 оны байдлаар Монголбанкнаас тогтоосон харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохистой хэмжээнд байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 20.1 хувь буюу доод хэмжээг 7.6 нэгж хувиар давуулан биелүүлсэн байна.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2025 оны 12 сарын 31-ний байдлаар 37.6 хувьтай байгаа нь зохистой харьцааг хангаж байна.

Санхүүгийн гол үзүүлэлтүүд

2025 оны жилийн эцэс


Цэвэр ашиг

Тэрбум төгрөг



Нийт актив

Тэрбум төгрөг




Зээлийн багц

Тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгийн өгөөж


Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.



1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа




Зээлийн үйл ажиллагаа

2025 оны жилийн эцэс

Нийт зээлийн тоо	Иргэдийн банк зээлийн тоо	Байгууллагын банк зээлийн тоо	ХасЛизинг санхүүгийн түрээсийн тоо	Онлайн зээлийн тоо
216.1 мянга +14.1% YTD	210.7 мянга	0.2 мянга	5.2 мянга	144.0 мянга +16.7% YTD



*- Иргэдийн банкны зээлийн багцад бичил ЖДБ зээл, ипотекийн зээл, хэрэглээний зээл багтсан болно.




Дотоод эх үүсвэр

2025 оны жилийн эцэс

Нийт дансны тоо	Харилцах дансны тоо	Хадгаламжийн дансны тоо	Нийт харилцагчдын тоо
1.5 сая ▲ 9.2% YTD	955.3 мянга	559.7 мянга	1.2 сая ▲ 8.0% YTD


Харилцах, хадгаламж

Тэрбум төгрөг



Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



- 2025 онд ХасБанкны харилцах, хадгаламжийн үлдэгдэл 3,479 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс 9.5% өссөн бөгөөд үүнд хүүхдийн хадгаламжийн өсөлт (+11.4%), харилцах дансны өсөлт (+9.4%), хугацаатай хадгаламжийн өсөлт (+8.3%) тус тус нөлөөлжээ.
- Тайлант хугацаанд “Нэг тэрбум төгрөг”-ийн шагналын сантай хадгаламжийн урамшуулалт аян болон Ирээдүйн саятан хүүхдийн хадгаламж нээх эрхийн бичигтэй урамшуулалт хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүллээ.


Гадаад эх үүсвэр

2025 оны жилийн эцэс

2025 онд Банк нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, Азийн Хөгжлийн Банк, BlueOrchard Finance, Incofin Investment Management, Developing World Markets, Finnfund болон Symbiotics зэрэг олон улсын болон хөгжлийн санхүүгийн байгууллагуудаас 263.2 сая ам.доллар болон 33.2 тэрбум төгрөгийн гадаад эх үүсвэр татан төвлөрүүлээ. 2025 онд татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зардал өмнөх жилүүдтэй харьцуулахад буурсан нь Банкны нийт эх үүсвэрийн зардлыг бууруулахад эерэгээр нөлөөлсөн бөгөөд өндөр зардалтай эх үүсвэрүүд бүрэн эргэн төлөгдөхийн хэрээр энэхүү чиг хандлага цаашид үргэлжлэх төлөвтэй байна. Мөн түүнчлэн, FMO-ийн ахалсан 150 сая ам.долларын синдикат зээлийн гэрээг амжилттай байгуулсан бөгөөд эх үүсвэрийн хэрэгцээнээс хамааран 2026 оны эхний хагас жилд тус эх үүсвэрийг татан төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байна.

Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



Шинээр гадаад эх үүсвэр олгосон байгууллагууд



Хувьцааны мэдээлэл

2025 оны жилийн эцэс

ХасБанк ХК (ХАС)-ийн хувьцааны үнэ 2025 оны 12 сарын 31-ны өдөр 963.9 төгрөгөөр хаагдсан нь өмнөх оны хаалтын ханшаас 16.7 хувь, IPO хийсэн үнээс 42.4 хувиар өслөө. 2025 оны IV улирлын байдлаар нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг 164.1 төгрөг байна.

ХасБанк ХК жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг Монголбанкны холбогдох зөвшөөрлийн дагуу 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд ХасБанк 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт 2,672,816 ширхэг (нийт эргэлтэд гаргасан хувьцааны 0.25%) хувьцааг халаасалсан байна.


2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 18 төгрөг буюу нийт 18.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваариллаа. Харин 2025 оны жилийн эцсийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 30 төгрөг буюу нийт 31.2 тэрбум төгрөгийг хуваарилахаар ТУЗ-өөс шийдвэрлэсэн бөгөөд зохицуулагч байгууллагын зөвшөөрөл болон 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлуулснаар ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд тараах болно.

ХАС хувьцааны ханш, арилжааны хэмжээ



Ногдол ашиг хуваарилалт

Тэрбум төгрөг



* - ХасБанкны IPO-ны үнэ болох 677 төгрөгт суурилсан тооцов

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


2025 оны жилийн эцэс

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

20.1% Байвал зохих доод хэмжээ 12.5%


Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

37.6% Байвал зохих доод хэмжээ 25.0%



Түргэн борлогдох актив

Нийт 2,257.5 тэрбум төгрөг



Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	2020	2021	2022	2023	2024	2025
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-1.8%	-1.1%	6.2%	-1.3%	-1.7%	-1.2%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-4.2%	-2.2%	6.9%	-1.4%	-2.0%	-1.2%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	77.2%	72.8%	66.6%	38.6%	41.7%	54.8%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	2.5%	1.7%	1.7%	1.3%	1.2%	1.1%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	7.0%	7.1%	7.7%	7.8%	7.9%	8.0%

	2020	2021	2022	2023	2024	2025
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%	0.8%	2.2%	2.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.2%	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	1.8%	1.8%	1.6%	3.2%	0.0%	0.0%

Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	0.0%	0.0%	0.0%	0.8%	2.3%	2.0%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.5%	0.4%	0.3%	0.3%	0.3%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	3.6%	4.5%	3.8%	3.2%	0.1%	0.1%

Сангаас хаасан зээлийн мэдээлэл

2025 оны жилийн эцэс

Сангаас хаасан зээл, бүтээгдэхүүнээр

Бүтээгдэхүүн	Сангаас хаасан зээлийн хэмжээ (сая төгрөгөөр)	Зээлийн тоо
Цалингийн зээл	799	69
Бичил бизнесийн зээл	105	4
Бусад хэрэглээний зээл	12	7
Нийт	916	80

Тэмдэглэл

- ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын хурлаар сангаас хаах зээлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэсэн;
- Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан тушаалаар баталсан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын шаардлагыг бүрэн хангасан зээлүүдийг сангаас хаасан;
- Банк нь зээлийг сангаас хааснаар өр төлүүлэх ажиллагааг зогсоохгүйгээр үргэлжлүүлдэг;
- Тиймээс сангаас хаасан зээлийг төлүүлэхтэй холбоотой шүүхийн журмаар өр барагдуулах ажиллагааг үргэлжлүүлж байна.



☎ (976)-75771888-(888)

✉ investor-relations@xacbank.mn

🌐 <https://www.xacbank.mn>

ХасБанк ХК-ийн Засаглалын тайлан

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан

1. ЗАСАГЛАЛЫН ТОЙМ
2. ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО
3. ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО
4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БА НЭГТГЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ
5. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ
6. НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ
7. ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ХӨТӨЛБӨР
8. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
9. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД
10. ЁС ЗҮЙН КОДЕКС, СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ БА ТОЛИЛУУЛГА
11. КОМПАНИЙН БҮТЭЦ
12. УДИРДЛАГЫН БАГ

1. ЗАСАГЛАЛЫН ТОЙМ

ХасБанк 2025 онд байгууллагын бүтэц, засаглалын тогтолцоонд стратегийн ач холбогдол бүхий шинэчлэлийг амжилттайгаар хэрэгжүүлэн дуусгаж, Банкны тухай хуульд заасан нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувь эзэмшлийн төвлөрөл 20%-иас хэтрэхгүй байх шаардлагыг хуулийн хугацаанаас даруй нэг жил гаруйн өмнө хангасан системийн нөлөө бүхий анхдагч банк боллоо.

Үүнээс гадна, тус онд ХасБанк ТУЗ-ийн үйл ажиллагааг хялбарчлах, хурдан шуурхай болгох, ил тод байдлыг сайжруулах зорилгоор засаглалын тогтолцоонд олон талт шинэчлэлүүдийг хийж, дотоод зохион байгуулалтыг олон улсын сайн туршлагад нийцүүлэн шинэ түвшинд хүргэлээ.



ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК ХасБанкинд нэгдсэнийг 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлснээр нэгтгэх ажиллагаа бүрэн дуусгавар болов. Энэ нь Банкны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2021 оноос эхлэн шат дараатай хэрэгжсэн, 5 жилийн хугацаанд үргэлжилсэн ТэнГэр Санхүүгийн Нэгдэлийн өөрчлөн байгуулалтыг албан ёсоор амжилттай өндөрлөсөн онцлох үйл явдал болов.



Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн үйл ажиллагааг хялбарчлан цахимжуулах, хурдан шуурхай болгох, ТУЗ-ийн түвшинд мэдээллийн хүртээмжтэй байдал, ил тод байдлыг сайжруулах, түүнчлэн, дотоод мэдээллийн алдагдлаас сэргийлэх зорилгоор NASDAQ BoardVantage платформыг ТУЗ-ийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн.



ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх журмыг нарийвчлан шинэчилж, хувьцаа эзэмшигчид нэр дэвшигчээ ТУЗ-д санал болгох үйл явцын үе шат, шаардлагыг тодорхой болгож, процессын ил тод, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэв.



СЗХ-ны зөвлөмжийн дагуу Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн шийдвэрээр "Нэр дэвшүүлэх хороо" болон "Засаглал, цалин урамшууллын хороо" хэмээх хоёр бие даасан хороонд хуваав.



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх ("МУТС")-тэй тэмцэх үүргийн хүрээнд холбогдох дотоод журмуудыг зохицуулагч байгууллагын шаардлагад бүрэн нийцүүлэн шинэчилсэн ба ингэхдээ харилцагч таньж мэдэх, гүйлгээний хяналт, сургалт мэдээлэл хүргүүлэх ажиллагааг нарийвчилсан байдлаар тусгалаа. Мөн МУТС-тэй тэмцэх эрсдэлийн үнэлгээний аргачлалыг шинээр батлуулсан ба ингэснээр аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотойгоор үүсэх эрсдэлийг бууруулах, цаашид авах арга хэмжээг оновчтой тодорхойлох боломжтой болов.



ХасБанк нь 2025 онд АНУ-д төвтэй, олон улсын стандарт тогтоогч байгууллага болох Дотоод Аудиторуудын Хүрээлэн (IIA)-гээр Монгол Улсад анх удаа “Чанарын үнэлгээ”-г амжилттай хийлгэж, “маш сайн” үнэлгээ авснаар 2024 онд шинэчлэгдсэн Олон улсын дотоод аудитын стандартыг бүрэн хангасныг баталгаажуулав.

ТУЗ-өөс баталсан бодлого, журам

Шинээр баталсан

- Залилангийн эсрэг ерөнхий журам
- Нэр дэвшүүлэх хорооны дүрэм
- Засаглал, цалин урамшууллын хорооны дүрэм

Нэмэлт, өөрчлөлт оруулсан

- ХасБанкны дүрэм
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлдэх бодлого
- Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам
- ХасБанкны засаглалын кодекс
- ТУЗ-ийн үнэлгээний журам
- ХасБанкны ногдол ашгийн бодлого
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм
- Дотоод аудитын дүрэм

Шинэчлэн баталсан

- ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, түүний залгамж халааг бэлдэх ерөнхий журам
- Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
- Харилцагчийг таньж мэдэх журам

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос баталсан Компанийн засаглалын кодекс-ийн удирдамжийн үнэлгээний аргачлалын дагуу ХасБанкны “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт”-ийн 2024 оны жилийн эцсийн тайланг СЗХ-ноос хянан баталгаажуулж **93.1%** буюу **засаглал сайн, эрсдэлгүй** гэж үнэлсэн. 2025 оны жилийн эцсийн үнэлгээ хараахан гараагүй байгаа тул тус оны хагас жилийн тайланг **95.8%** буюу **засаглал сайн, эрсдэлгүй** гэж үнэлснийг танилцуулж байна.

Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай Монголын хөрөнгийн бирж ХК болон компанийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

№	Гарчиг	Авбал зохих оноо	2024.12.31-ний байдлаар		2025.06.30-ны байдлаар		Өөрчлөлт хувь
			СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	%
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	83.3%	10	83.3%	-
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7	70%	9	90%	20%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100%	6	100%	-
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%	6	100%	-
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%	-
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	6	100%	-
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%	-
8	Компанийн соёл	6	6	100%	6	100%	-
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%	10	100%	-
Нэгдсэн дүн		72	67	93.1%	69	95.8%	2.7%

2. ХАСБАНКНЫ ЗАСАГЛАЛ

ХасБанк нь өөрийн Засаглалын Кодекс (2023)-ийн дагуу ХасБанкны засаглалын тогтолцоог хувь нийлүүлсэн хөрөнгийн үнэ цэнийг урт хугацаанд нэмэгдүүлэх зорилго бүхий, Банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ, гүйцэтгэх удирдлага хоорондын удирдлага, хяналтын цогц бүтэц болон үйл ажиллагаа гэж тодорхойлдог.

Банкны засаглал нь дараах зарчимд үндэслэнэ:



Банкны засаглалын бүтэц:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хувьцаа эзэмшигчдэд банкны засаглалд оролцох боломжийг олгодог банкны эрх барих дээд байгууллага байна.
- ХасБанкны ТУЗ нь Банкны үндсэн үйл ажиллагааг стратегийн удирдлага, өргөн хүрээний хяналтаар хангах үндсэн чиг үүрэгтэй. ТУЗ-ийн дэргэд Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх гэсэн 4 хороод үйл ажиллагаа явуулдаг.
- Гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын баг нь Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, стратегийг хэрэгжүүлж ажиллана.

3. ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО

ХасБанкны Дотоод аудитын алба нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд шууд тайлагнадаг бөгөөд үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан байх зарчмын хүрээнд хэрэгжүүлдэг. Тус алба нь Газар дээрх аудитын хэлтэс болон Зайны аудитын хэлтэс гэсэн бүтэцтэйгээр нийт 17 аудитортай үйл ажиллагаа явуулж байна.

Зайны аудитын хэлтэс нь үргэлжилсэн аудитын хүрээнд автомат хяналтын дүрэм, хяналтын самбаруудыг ашиглан банкны үндсэн үйл ажиллагаанд тасралтгүй хяналт хэрэгжүүлж, зөрчил, эрсдэлтэй үйлдэл болон гүйлгээг цаг алдалгүй илрүүлснээр болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Газар дээрх аудитын хэлтэс нь батлагдсан аудитын аргачлал болон олон улсын дотоод аудитын стандартын дагуу аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж, банкны эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөг хараат бус байдлаар үнэлэн, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмжөөр удирдлагыг тогтмол ханган ажиллаж байна.

2025 онд ХасБанк нь АНУ-д төвтэй, олон улсын стандарт тогтоогч байгууллага болох Дотоод Аудиторуудын Хүрээлэн (IIA)-гээр Монгол Улсад анх удаа “Чанарын үнэлгээ”-г амжилттай хийлгэж, “маш сайн” үнэлгээ авснаар 2024 онд шинэчлэгдсэн Олон улсын дотоод аудитын стандартыг бүрэн хангасныг баталгаажууллаа.

Энэхүү үнэлгээ нь ХасБанкны засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо олон улсын сайн жишигт нийцэж буйг нэр хүнд бүхий хараат бус байгууллагаар баталгаажуулсан чухал алхам бөгөөд ил тод, хариуцлагатай засаглалыг эрхэмлэсэн бодлого, тогтвортой хөгжлийн зорилтууд бодитоор хэрэгжиж буйн тод илрэл юм.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

ХасБанк нь эрсдэлийн удирдлагыг Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын хүрээнд хэрэгжүүлдэг. Эрсдэлийн удирдлагын зорилго нь Банкны стратегийн зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлэх, санхүүгийн тогтвортой байдал болон зохицуулагч байгууллагын шаардлагыг хангах, бизнесийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэлийг удирдахад чиглэсэн байдаг.

Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогыг ТУЗ баталж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”) нь бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, бизнесийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, удирдах үйл явцыг нэгдсэн удирдлагаар хангадаг. Банкны Гүйцэтгэх удирдлага нь эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг тус хороонд тайлагнаж, эрсдэл даах чадвар болон хязгаар нөхцөлийн хүрээнд үйл ажиллагааг удирдан ажиллаж байна.

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлах бөгөөд Банкны бүх нэгж өөрийн үйл ажиллагааны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, тайлагнах чиг үүрэгтэй.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Зээлийн эрсдэл нь Банкны удирдах ёстой гол эрсдэлийн нэг бөгөөд зээлийн үйл ажиллагааг Банкны ТУЗ-ийн баталсан Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлэх замаар зээлийн багцын чанарыг тогтвортой бага түвшинд барьж ажилладаг. Төвлөрлийн эрсдэлийг бууруулахын тулд Банкны тухай хууль, тогтоомжид заасан зээлийн төвлөрөлтэй холбоотой хязгаар нөхцөлүүдийг хангаж ажиллахаас гадна эдийн засгийн сектор, зээлийн бүтээгдэхүүний дотоод лимитүүдийг тогтоон мөрдөн ажилладаг.

Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн шинжилгээ

Банкны эрсдэлийн удирдлагын нэгж нь ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ-нд улирал бүр, гүйцэтгэх удирдлагын дэргэдэх ЭУХ-нд сар бүр Нэгдсэн Эрсдэлийн Тайлан, холбогдох эрсдэлийн шинжилгээг танилцуулж, шаардлагатай шийдвэрүүдийг гаргаж хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажилладаг. Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг банкны бизнес төлөвлөгөө, стратегитэй уялдуулан жил бүр ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ-гоор шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлдэг.

2025 онд Банк нь зах зээлийн гол хувьсагчид болох хүү, гадаад валютын ханш, үнийн хэлбэлзлээс үүдэх эрсдэлийг үнэлж, санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнэ болон мөнгөн урсгалд учирч болзошгүй нөлөөллийг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинд удирдсан. Түүнчлэн зохицуулагч байгууллагаас тогтоосон санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийн бүхий л үзүүлэлтүүдийн хувьд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хязгаарын хүрээнд тогтмол хангаж ажиллалаа.

ХасБанк нь 2023 оноос эхлэн Базел III олон улсын жишгийн дагуу өөрийн хөрөнгийн хэрэгцээг дотооддоо үнэлэх ICAAP (Internal Capital Adequacy Assessment Process) болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх ILAAP (Internal Liquidity Adequacy Assessment Process) аргачлалуудыг боловсруулж, жил бүр үнэлгээг хийж банкны эрсдэлийн нэгдсэн удирдлага болон стратеги төлөвлөлтөдөө нэвтрүүлэн ашиглаж байна.

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд Банк нь хөрвөх чадварын нөөц (liquidity buffer), богино хугацаат хөрвөх чадварын үзүүлэлт (short-term liquidity ratio), хөрвөх чадварын хүрэлцээний харьцаа (LCR), цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR) зэрэг үзүүлэлтүүдийг тогтмол хянаж, өөрсдийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээнд удирдаж ажиллахын зэрэгцээ Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллалаа.

Зээлийн багцын чанар, төвлөрлийн эрсдэлийг ТУЗ-өөс баталсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарын хүрээнд удирдаж ажиллахаас гадна ICAAP аргачлалын хүрээнд төвлөрлийн эрсдэл болон хүүгийн эрсдэлд шаардагдах өөрийн хөрөнгийн шаардлагыг жил бүр тодорхойлж ICAAP тайланд тусгадаг.

Түүнчлэн гэнэтийн хүндрэлт нөхцөл байдал үүсэхэд Банкны санхүүгийн байдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадварт үүсч болох нөлөөллийг тодорхойлох зорилгоор стресс тестийн шинжилгээг тогтмол хийж гүйцэтгэн, түүний үр дүнг гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-н түвшинд хэлэлцүүлж, удирдлагын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Банкны хяналтын орчныг бэхжүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. ХасБанк нь ТУЗ-өөс баталсан Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын хүрээнд үйл ажиллагааны эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшин, хэм хэмжээг тодорхойлж, Хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлан удирдаж байна.

Хамгаалалтын гурван бүсийн загварын дагуу газар, нэгжүүд өөрийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээг хийж хэвшсэн ба хүний хүчин зүйл, дотоод процесс, мэдээллийн технологийн алдаа доголдлоос үүсэх аливаа эрсдэлийг эрт илрүүлж, давтагдахаас урьдчилан сэргийлэх хяналтыг тогтмол сайжруулан ажиллаж байна.

Нийгэм, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн удирдлага

Банк нь Нийгэм, байгаль орчны эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах эрсдэл нь банкны үйл ажиллагаанд тодорхой эрсдэл бий болгоно гэдгийг хүлээн зөвшөөрч олон улсын сайн туршлага, стандартуудад нийцсэн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.

Өнгөрсөн жилүүдэд бид уур амьсгалын эрсдэлийн удирдлагын шилжилтийн замын зураглалаа батлан,

шилжилтийн төлөвлөгөө боловсрууллаа. Түүнчлэн бид засаглал, стратеги, эрсдэлийн удирдлага, хэмжүүр үзүүлэлтүүд болон зорилтуудын хүрээнд тайлагналаа сайжруулсаар байна. Энэ хүрээнд бид банкны санхүүжүүлсэн зээлийн ялгаруулж буй хүлэмжийн хийг тооцох дата өгөгдөлийн чанарыг сайжруулж, Partnership for Carbon Accounting Financials (PCAF)-д “Тайлагнасан” статус авлаа.

Цаашид зээлийн болон бизнесийн үйл ажиллагааны нийгэм, байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл, эрсдэлийн тооцооллын арга аргачлалыг тогтмол сайжруулахын зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн банкны үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөлөл, үүнтэй холбоотой хүлээн зөвшөөрөх эрсдэлүүдийн хэм хэмжээг тодорхойлон ажиллана.

Комплаенс

Банкны комплаенсын функцийн эрхэм зорилго нь ХасБанкны Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын хүрээнд өндөр стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, банкны тогтвортой бизнесийн үйл ажиллагааг хангаж улмаар дотоод болон гадаад түншлэлээр дамжуулан Банк, харилцагчид болон олон нийтийн харилцаанд эерэг үр дүнд хүрэхэд оршино. Түүнчлэн, банкны нэр хүндийг хамгаалах, ёс зүйн стандарт болон хууль эрх зүйн үүргээ биелүүлэхийн тулд дотоод хяналтын арга хэмжээг хэрэгжүүлдэг.

ХасБанк бизнесийн үйл ажиллагаагаа амжилттай явуулахын сацуу комплаенсын эрсдэл буюу санхүүгийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлага, тухайн салбарын бизнесийн болон мэргэжлийн ёс зүйн стандартыг дагаж мөрдөөгүйгээс үүсэх эрсдэлийг тогтмол хянаж ажилладаг. Ялангуяа санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, залилан болон авлига, хээл хахуультай тэмцэх зохицуулалтууд нэн тэргүүнд байдаг.


2025 онд Монгол улсад цахим мөрийтэй тоглоомыг хязгаарласантай холбоотойгоор Комплаенсын газар нь тус төрлийн гүйлгээ хийж буй харилцагч нарын гүйлгээг хязгаарлах, зогсоох чиглэлийн ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулан ажиллаж байна.

Банкны аливаа үйл ажиллагаа тогтсон дотоод дүрэм журам, зохицуулалтын дагуу хэрэгжих шаардлагатай ба тэдгээр нь цаг үеийн онцлогтой нийцэн тогтмол хяналт хийгдэн шинэчлэгдэж байдаг. Үүний дагуу ХасБанкны МУТС-тэй тэмцэхтэй холбогдох дотоод журмуудыг бүрэн шинэчлэн сайжрууллаа. Банкны нийт ажилтнуудад холбогдох хуулиуд болоод журмын шинэчлэл, санхүүгийн гэмт хэрэг, МУТС болон ёс зүйн хэм хэмжээний талаар тогтмол мэдлэг олгох арга хэмжээ болон сургалтуудыг зохион байгуулан ажиллалаа.

ФАТФ-ын Ази номхон далайн бүсийн байгууллагаас хийгдэх Монгол улсын дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэх ажлын хүрээнд хийгдэж буй МУТС Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэгт ХасБанкны төлөөллүүд туршлага мэдлэгээ солилцон оролцож байна.

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

ХасБанк нь 2025 онд Банкны тухай хуульд заасан нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувь эзэмшлийн төвлөрөл 20%-иас хэтрэхгүй байх шаардлагыг хуулийн хугацаанаас даруй нэг жил гаруйн өмнө хангасан системийн нөлөө бүхий анхдагч банк болсон билээ. Ийнхүү ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд амжилттай нэгтгэж дууссанаар тус толгой компаниар дамжуулан ХасБанкинд хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигч нар дараах байдлаар шууд хувь эзэмших болсон байна.



* Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид (5% буюу түүнээс дээш хувьцаа хувьцаа эзэмшигчид)-ээр задлан харуулав.

5. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн, Банкны нийт гаргасан хувьцааны ердийн олонх буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар:

- Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг
- Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг
- ХасБанкны дүрмийн 8.6 дахь хэсэгт заасан асуудлуудыг тус тус хэлэлцэж, шийдвэрлэдэг.

ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах өдрүүдэд зохион байгуулагдав.

Хурлын огноо	Ээлжит/ ээлжит бус	Санал хураалтын хэлбэр	Хурлын ирц
2025.04.29	Ээлжит	Танхим болон цахим хосолсон	96.01%
2025.07.25-08.26	Ээлжит бус	Эчнээ	95.45%
2025.09.18-10.10	Ээлжит бус	Эчнээ	79.13%

Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон шийдвэрүүдтэй ХасБанкны цахим хуудасны “Хувьцаа эзэмшигчдийн хурал” цэс буюу [ЭНД](#) дарж танилцана уу.

6. НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

ХасБанк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон зохицуулагч байгууллагаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, ирээдүйн бизнесийн тэлэлтийн боломж, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын цаашдын чиг хандлага зэргийг харгалзан үзэж хуримтлагдсан ашгаас **ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг жилд 2 удаа хэлэлцэн, шийдвэр** гаргадаг.

Энэхүү ногдол ашгийн бодлогын хүрээнд ХасБанк нь 2025 онд хуваарилсан ногдол ашгийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

Ногдол ашиг	Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүн /төгрөг/	Шийдвэрийн огноо	Хувьцаа эзэмшигчийн нэрийн дансанд байршуулж дууссан огноо
2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хуваарилсан ногдол ашиг	27.00	2025.04.29	2025.04.29
2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас хуваарилсан ногдол ашиг	18.00	2025.10.10	2025.10.16
2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хуваарилахаар хүлээгдэж* буй ногдол ашиг	30.00	2025.02.16	-

*ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн R-2026-02 тоот тогтоолоор Банкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 30.00 (гуч) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд жилийн эцсийн ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд тус шийдвэрийг Монголбанкнаас зөвшөөрч, Банкны Дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсны дараагаар ногдол ашгийг хуваарилахаар хүлээгдэж байна.

7. ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ХӨТӨЛБӨР

ХасБанк өөрийн жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 2 дугаар хагасаас хойш 2025 оныг дуустал хугацаанд хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг 4 удаагийн шийдвэрээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хүрээ хязгаарлагдмал, хувьцааны хөрвөх чадвар сул байгаа өнөөгийн нөхцөлд жижиг хувьцаа эзэмшигчид нь хүссэн үедээ цал алдалгүйгээр өөрийн эзэмшиж буй хувьцаагаа мөнгөжүүлэхэд хүндрэлтэй байдаг. Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр нь нээлттэй, ил тод байдлаар, зохицуулагч байгууллагын зөвшөөрөлтэйгөөр хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлж жижиг хувьцаа эзэмшигчдэд учирч буй хүндрэлийг бууруулах зорилготой.


Уг хөтөлбөр нь банкны өөрийн хөрөнгийг бууруулахад чиглээгүй бөгөөд зөвхөн жижиг хувьцаа эзэмшигчдэд туслах зорилготой болно. Иймд, Банк нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаагаа өндөр түвшинд хадгалах бодлогоо тогтвортой хэрэгжүүлнэ. Одоогийн байдлаар ТУЗ нь халаасны хувьцааг эргэлтэд оруулах тухай хэлэлцэж байгаа бөгөөд халаасны хувьцааг хэрхэх талаар шийдвэрлэсний дараа ХасБанк нь Хувьцаа эзэмшигчид, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос шаардлагатай зөвшөөрлүүдийг зохих журмын дагуу тухай бүрд авах болно.

Хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХасБанк нь нийт гаргасан 1,052,700,000 ширхэг хувьцааны 0.25% болох 2,672,816 ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслаад байна. Энэхүү халаасалсан хувьцааг Компанийн тухай хуулийн дагуу эргэлтэд гаргах асуудлыг ТУЗ хянан хэлэлцэж байгаа бөгөөд холбогдох зохицуулагч байгууллагын зөвшөөрөлд үндэслэн Хувьцаа эзэмшигчдээр шийдвэрлүүлэх болно.


8. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ТУЗ нь Банкны дүрмийн дагуу 12 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн 12 гишүүнийг кумулятив аргаар сонгосон. ТУЗ-ийн гишүүн Албертус Браггинк нь өөрийн хүсэлтээр 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тул ХасБанкны ТУЗ нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 11 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллав. Тодруулбал, ТУЗ-ийн дарга 1, Гүйцэтгэх удирдлагын төлөөлөл болох 1 гишүүн, Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 5 гишүүн болон хараат бус 4 гишүүнээс бүрдэнэ.



- ТУЗ-ийн дарга
- ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагын гишүүн
- Хараат бус гишүүн
- Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл



- Эрэгтэй
- Эмэгтэй

ХасБанкны ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлыг харгалзан үзэхийн зэрэгцээ Банкны нийтлэг эрх ашгийг бүхэлд нь хамгаалах чадамжтай, өргөн хүрээний мэдлэг, туршлага бүхий, хараат бус, үр нөлөөтэй шийдвэр гаргах боломжийг хангахуйц бүтэц, зохион байгуулалттай байхаар зохицуулагдсан.

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгодог. ТУЗ-ийн гишүүд дахин сонгогдох эрхтэй.



САНЖАЙ ГҮПТА

ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн дарга нь ХасБанкны толгой компани ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (ТСН)-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байсантай холбоотойгоор хараат бус гишүүнд тооцогддоггүй боловч ХасБанкны аль нэг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс хамааралгүй гишүүн болно.

Мэргэшсэн чиглэл

Эдийн засаг, санхүү

Санхүүгийн зах зээлд

тасралтгүй ажилласан туршлага

45 жил

Боловсрол

Дели дэх Сэинт Стивинг коллеж, Физикийн шинжлэх ухааны бакалавр

Дели Их Сургуулийн Менежментийн факультет, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага

1981-2001	БНЭУ, Англи болон ХонгКонг дахь Америкийн Банк, Байгууллагын банк хариуцсан захирал (Энэтхэг); Байгууллагын санхүүжилт хариуцсан захирал (Энэтхэг); Санхүүгийн байгууллага хариуцсан захирал (Энэтхэг); Европ, Ойрх Дорнод, Африкийн (ЕОДА) орнуудад Гүйцэтгэх захирал болон Эрсдэлийн удирдлага хариуцсан захирал; ЕОДА-ийн Стракчард Кредит Группийн Гүйцэтгэх захирал; Ази дахь Инвестмент Банкинг Группийн Гүйцэтгэх захирал
2001-2005	Кредит Лионасс Ази, Номхон далайн бүс, Зээл хариуцсан захирал
2006-2015	Кредит Агриколь Групп, Ази дахь зээлийн дахин санхүүжилт хариуцсан захирал, Глобал Энержи Групп, Ази хариуцсан захирал
2017-2019	ТСН ХХК, ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2019-2025	ТСН ХХК, ТУЗ-ийн дарга (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2019 оноос	ХасБанкны ТУЗ-ийн дарга

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар: 851,541 ширхэг (0.08%)



АЛБЕРТУС БРАГГИНК

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар ажиллаж байсан бөгөөд 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдсөн. ОРИКС группээс нэр дэвшүүлсэн.

Мэргэшсэн чиглэл

Санхүү

**Санхүүгийн зах зээлд
тасралтгүй ажилласан туршлага** 39 жил

Боловсрол Нидерландын Твенте Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр болон доктор

Ажлын туршлага

1986-2016	Нидерландын Рабо банк, Санхүү, Эрсдэл хариуцсан захирал, Санхүү, хяналт шалгалтын захирал
2016-2025	ОРИКС Групп, ТУЗ-ийн зөвлөх
2021-2025	ТСН ХХК, ТУЗ-ийн гишүүн (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2021-2025	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа
Хувьцаа эзэмшдэггүй.

* ТУЗ-ийн гишүүн Албертус Браггинк нь үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт ирүүлснийг ТУЗ хүлээн авч, 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн R-2025-42 тоот тогтоолоор 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн албан тушаалаас чөлөөлсөн.



ЭМИ ЧОЙ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл

Мэдээллийн системийн шинжилгээ, бизнесийн шинжилгээ

Санхүүгийн зах зээлд

тасралтгүй ажилласан туршлага 41 жил

Боловсрол

Хонконгийн Политехникийн Их Сургууль, Мэдээллийн системийн шинжилгээ ба дизайны чиглэлээр ахисан түвшний диплом

Лондонгийн Сити Их Сургууль Бизнесийн шинжилгээ, дизайны чиглэлээр шинжлэх ухааны магистр

Ажлын туршлага

1982-1993	Хонконг дахь АйБиЭм Банк, Системийн инженер, Ахлах инженер, Санхүүгийн үйлчилгээний систем хариуцсан менежер (Даатгалын автоматжуулалт болон Банкны үйл ажиллагаа)
1994-2010	Ситибанк Хонг Конг, Салбарын менежер, Олон улсын хувийн банк хариуцсан албаны захирал, Ерөнхий захирал (Салбарын борлуулалт, түгээлт)
2010-2013	Хятадын Гуангфа Банк, Иргэдийн банк хариуцсан гүйцэтгэх дэд ерөнхийлөгч
2013-2017	Пинг Ань Банк, Иргэдийн банк хариуцсан дэд ерөнхийлөгч
2017-2020	Хятадын Зүүн Азийн Банк, Гүйцэтгэх захирлын орлогч
2023 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Хувьцаа эзэмшдэггүй.



АНДЖЕЙ ВИТАК

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, ЕСБХБ-наас нэр дэвшүүлсэн

Мэргэшсэн чиглэл

Банк, санхүү

Санхүүгийн зах зээлд
тасралтгүй ажилласан туршлага 41 жил

Боловсрол Польш Улсын Силезиа Их Сургууль, Хууль зүйн магистр

Ажлын туршлага

1983-1984	Ти Дабль Ю Ди, Экспорт-импортын мэргэжилтэн
1985-1987	Фоско, Санхүүгийн ахлах мэргэжилтэн
1987-1990	Корект, Бие даасан зөвлөх
1990-1991	Гливице Банк, Дэд ерөнхийлөгч
1992-1997	Польшийн Хандлово Банк, Польшийн Төв банкнаас томилогдсон эрх хүлээн авагч, менежер
1997-2007	Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Ахлах банкир, Украин Улс хариуцсан Дэд захирал
2007 оноос	Бие даасан зөвлөх
2019-2025	ТСН ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2019 оноос	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа
Хувьцаа эзэмшдэггүй.



ДОМИНИК ЖАК

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, Канадын үндэсний банкнаас нэр дэвшүүлсэн

Мэргэшсэн чиглэл

Банк, санхүү, аудит

Санхүүгийн зах зээлд
тасралтгүй ажилласан туршлага 25 жил

Боловсрол Монреалийн Их Сургууль, Бизнесийн удирдлагын бакалавр
Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр ахисан түвшний диплом
Мэргэшсэн нягтлан бодогч (CPA) ба мэргэшсэн санхүүгийн шинжээч (CFA).

Ажлын туршлага

2001-2009	Прайс УатерХаус Күүперс компани, Ахлах шинжээч, Менежер, Ахлах менежер
2010-2014	Канадын Үндэсний Банк, Ахлах ерөнхийлөгч
2014 оноос	Канадын Үндэсний Банк, Олон улсын асуудал хариуцсан Тэргүүн дэд ерөнхийлөгч
2015-2019	Афрашиа Банк Лимитед, ТУЗ-ийн гишүүн
2016 оноос	Эй-Би-Эй Банк, Камбож, ТУЗ-ийн гишүүн
2016 оноос	ЭйТиЭй АйТи, Тайланд, ТУЗ-ийн гишүүн
2018-2025	НСИА Партиципейшн Кот-д'Ивуар, ТУЗ-ийн гишүүн
2018-2025	НСИА Банк Кот-д'Ивуар, ТУЗ-ийн гишүүн
2024 оноос	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2025 оноос	Эй-Би-Эй Траст Ко Эл Ти Ди, ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа
Хувьцаа эзэмшдэггүй.



МАЙКЛ МАДДЕН

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, цалин урамшууллын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Ронок Партнерз Кэй Эф Ти компаниас нэр дэвшүүлсэн

Мэргэшсэн чиглэл

Санхүү, хөрөнгө оруулалт

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага

30 гаруй зах зээлд 36 жилийн туршлагатай

Боловсрол

Ирланд улс, Менежментийн Судалгааны Коллеж, Аж үйлдвэрийн инженерийн чиглэлээр диплом

Компанийн засаглалын хөгжлийн төв, Компанийн засаглалын гэрчилгээ

Ажлын туршлага

1993-2003	Американ Экспресс санхүүгийн байгууллагын Ирланд, Их Британи болон ОХУ дахь салбар, Удирдах албан тушаал
2003-2007	Банк Ренесанс Кредит, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
2007 оноос	Ронок компани (шинэ зах зээлийн хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээ), Үүсгэн байгуулагч, Удирдах түнш
2009-2025	ТСН ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн (ХасБанкинд нэгтгэсэн)
2011-2024	Тенео, ТУЗ-ийн дэд дарга; Капитал Адвайзори, ТУЗ-ийн дарга
2009 оноос	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2015 оноос	Ронок Азиа ПиТиИ ЭлТиДи, ТУЗ-ийн дарга
2024 оноос	Конселло Групп, Партнер

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Шууд хувьцаа эзэмшдэггүй.



НИРАЖ ВЭДВА

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл

Мэдээллийн технологи, худалдаа, бизнес

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага

32 жил

Боловсрол

Дели Их Сургууль, Эдийн засгийн чиглэлээр бакалавр
Индира Гандигийн нэрэмжит Их Сургууль, Худалдаа,
маркетингийн чиглэлээр магистр

Ажлын туршлага

1989-1994	Нэтворк Лимитед компани, Дүүргийн худалдааны менежер
1994-1997	ТиЭнТи Экспресс, Хойд Энэтхэг, Балба бүсийн худалдааны менежер
1997-1999	Модикорп компани, Дотоод худалдааны менежер,
1999-2011	Нуклеус Софтвэр, Үйл ажиллагаа хариуцсан захирал
2011-2013	Швейцар Улсын Темонос компани, Ази, Номхон Далайн Бүсийн захирал
2013-2019	Тек Махиндра, Банк, төлбөр тооцоо, карт олон улсын хэмжээнд хариуцсан захирал
2018 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн
2019 оноос	Акселерик Эф Зи компанийн Гүйцэтгэх захирал

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа
Хувьцаа эзэмшдэггүй.



СТЮАРТ ХОЛЛ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, цалин урамшууллын хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл

Санхүү, Нягтлан бодох

Санхүүгийн зах зээлд
тасралтгүй ажилласан туршлага 43 жил

Боловсрол Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльсийн Их Сургууль, Худалдааны бакалавр
Австралийн Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт,
Мэргэжлийн практик сургалтын хөтөлбөр

Ажлын туршлага

1883-1985	Туш Росс энд Ко, Мэргэшсэн нягтлан бодогч
1985-1986	Фокс Ассошиэт, Мэргэшсэн нягтлан бодогч
1886-1994	Американ Экспресс Банк, Захирал
1994-2013	Стандарт Чартеред Банкны Индонез, Сингапур, Филиппин, Вьетнам, Өмнөд Солонгос болон Лондон дахь салбар, Удирдах албан тушаал
2013-2017	ДиЖейЭм Капитал Лимитед, ТУЗ-ийн дарга
2018-2021	Индонез Улс дахь Катарын Үндэсний Банк, Зөвлөх болон Гүйцэтгэх захирал
2022-2025	Пиур Фүүд Аллианс, ТУЗ-ийн гишүүн
2024 оноос	Графаит Өэрт, ТУЗ-ийн гишүүн
2024 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа
Хувьцаа эзэмшдэггүй.



СЮЗАННА КАРР

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, Олон Улсын Санхүүгийн Корпорациас нэр дэвшүүлсэн

Мэргэшсэн чиглэл

Хөрөнгө оруулалт, санхүү

Санхүүгийн зах зээлд
тасралтгүй ажилласан туршлага 39 жил

Боловсрол АНУ, Дьюкийн Их Сургууль, Эдийн засгийн бакалавр

Ажлын туршлага

1987-1993	АНУ-ын Филадельфия, Пенсильвания муж дахь Фёрст Фиделити Банк Корпорейшн/СМС Компаниуд, Хөрөнгө оруулалтын банкир
1994-1995	Варшав, Польш, АНУ дахь Эв Санааны Нэгдэл Үйлдвэрчний Эвлэл/Энх тайвны Корпус, Бизнесийн зөвлөх
1996-2019	Вашингтон хотын Дэлхийн Банкны Группын гишүүн; Олон Улсын Санхүүгийн корпораци, Зээлийн багц, бодлого ба технологи хариуцсан удирдах албан тушаал
2018-2023	Люксембургийн Бичил санхүүгийн хөгжлийг дэмжих сан, ТУЗ болон Хөрөнгө оруулалтын хорооны гишүүн
2020-2024	ПроКредит Банк, Белград, Серб улс, ТУЗ-ийн гишүүн
2021-2022	Дэлхийн Банкны Хараат бус үнэлгээний групп, Зөвлөх
2022-2025	ТСН ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2022 оноос	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2024 оноос	Трипл Жампын Хөрөнгө оруулалтын комиссын гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа
Хувьцаа эзэмшдэггүй.



НЯМТАЙШИР ЦЭЛМҮҮН

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, цалин урамшууллын хорооны гишүүн, МАК Инвест ЭсЖи ПиТиИ ЭлТиДи компаниас нэр дэвшүүлсэн

Мэргэшсэн чиглэл

Хөрөнгө оруулалт, бизнес

Санхүүгийн зах зээлд
тасралтгүй ажилласан туршлага 21 жил

Боловсрол АНУ-ын Индиана мужийн Вальпараисо Их Сургууль,
Бизнесийн удирдлага чиглэлээр бакалавр
ХонгКонгийн Стэнфордын Их Сургууль, Харвардын Бизнесийн
сургууль, Санхүүгийн инженерчлэлийн чиглэлээр гэрчилгээ

Ажлын туршлага

2005-2007	Худалдаа хөгжлийн банк, Төслийн Санхүү хариуцсан менежер
2007-2010	Монголын Алт ("МАК") ХХК, Ахлах мэргэжилтэн
2010-2012	Монголын Алт ("МАК") ХХК, Худалдаа болон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн газрын захирал
2012-2016	Монголын Алт ("МАК") ХХК, Худалдаа, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд ерөнхийлөгч, Бодлогын зөвлөлийн гишүүн
2012-2025	ТСН ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2012 оноос	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2016 оноос	Монголын Алт ("МАК") ХХК, Ерөнхийлөгч/ Гүйцэтгэх захирал
2018-2024	Премиум Бюлдинг Материалс, ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа
Шууд хувьцаа эзэмшдэггүй.



ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ

ТУЗ-ийн гишүүн бөгөөд Гүйцэтгэх захирал

Мэргэшсэн чиглэл

Банк, санхүү

Санхүүгийн зах зээлд

тасралтгүй ажилласан туршлага 22 жил

Боловсрол

АНУ-ын Колорадогийн Их Сургууль, Бакалавр

Рэжис Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага

2004-2008	АНУ дахь Уагнер Экьюпмент, Санхүү/Хөрөнгийн шинжээч, Олон улсын нягтлан бодогч
2008-2010	Сан Франциско хот дахь Рэсторэйшн Хардвэйр компани, Хөрөнгө зохицуулалтын менежер; Блүфин Ассосиетс (Пламслийс) компани, Санхүү хариуцсан захирал
2011-2019	ХасБанк, Иргэдийн банк хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал, ХасЛизинг ХХК, Гүйцэтгэх захирал, Тэнгэр Даатгал ХХК, ТУЗ-ийн дарга, Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д Санхүү хариуцсан захирал
2019-2025	ТСН ХХК, Гүйцэтгэх захирал (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2019 оноос	ХасБанкны Гүйцэтгэх захирал болон ХасБанкны ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар: 2,957,528 ширхэг (0.28%)



БАЯНСАНЫ УЛАМБАЯР

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хороо, Засаглал, цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл

Мэдээллийн технологи, бизнесийн удирдлага

**Санхүүгийн зах зээлд
тасралтгүй ажилласан туршлага** 19 жил

Боловсрол Токиогийн Технологийн Их Сургууль, Электроникийн инженерийн бакалавр болон магистр
АНУ-ын Чикагогийн Их Сургуулийн Бизнесийн сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага

2001-2005	Сони Корпораци, Инженер
2007-2009	Лиман Бродерс/Номура Секьюритис, Хөрөнгө оруулалтын банкир
2009-2011	Алтай Холдинг ХХК, Дэд захирал, Гүйцэтгэх захирал
2011-2012	Монет ХХК, Зөвлөх/ТУЗ-ийн дарга
2010-2012	Скайтел ХХК, ТУЗ-ийн гишүүн
2011-2012	Композит Капитал, Гүйцэтгэх захирал,
2013 оноос	Говь Бизнес Финанс ХХК, Зөвлөх
2014-2016	Дрэйпер Капитал, Ахлах зөвлөх
2015 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа
Хувьцаа эзэмшдэггүй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Нийт хурал	Цахим санал хураалт	Хэлэлцсэн асуудал	Баталсан тогтоолын тоо
8	8	61	55

Хурлын ирц		Цахим санал хураалтын оролцоо
100.00%	Санжай Гүпта	100.00%
92.00%	Албертус Браггинк	100.00%
100.00%	Эми Чой	100.00%
100.00%	Анджей Витак	100.00%
93.00%	Доминиш Жак	100.00%
100.00%	Майкл Мадден	63.00%
100.00%	Нираж Вэдва	100.00%
85.00%	Стюарт Холл	100.00%
94.00%	Сюзанна Херринг Карр	100.00%
58.00%	Н.Цэлмүүн*	38.00%
100.00%	Г.Цэвэгжав	100.00%
100.00%	Б.Уламбаяр	100.00%

* Тайлант хугацаанд тус гишүүний ирц хувийн шалтгааны улмаас тасалдсан болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ХӨЛС

ТУЗ-ийн гишүүний хөлсний хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог. ТУЗ-ийн гишүүд ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хорооны хуралд оролцох болон холбогдох бусад үүрэг хариуцлагыг гүйцэтгэхтэй холбоотой хөлс авдаг ба энэ нь түүний оролцох шаардлагатай ТУЗ, түүний хороо болон хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцээс хамааран тодорхойлогдоно. Хөлсийг улирал тутамд олгоно. Банкинд давхар албан тушаал хашдаггүй ТУЗ-ийн гишүүн хувьцаа эзэмшигчдээс тогтоосон хөлс, хороо удирдсантай холбогдуулан олгох нэмэгдлээс өөр бусад хөлс, шагнал урамшуулал авдаггүй.

ТУЗ-ийн гишүүний хөлсийг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний хувьцаа эзэмшигчдийн хурлаар шинэчлэн тогтоосон. Тогтоолтой [эндээс](#) танилцах боломжтой.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮНЭЛГЭЭ

Зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ нь хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр ТУЗ-ийн үйл ажиллагааны үнэлгээг хийдэг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн ТУЗ-ийн гишүүд бусад гишүүдийн үнэлгээг тус бүр хийдэг.

ТУЗ-ийн үйл ажиллагааны болон гишүүдийн үнэлгээ нь компанийн засаглалын сайн туршлагад тооцогддог бөгөөд ТУЗ-ийг бэхжүүлэх сул талыг олж илрүүлэх, чадамжийг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, бүтцийн талаар гишүүдийн дунд санал солилцох боломж олгодог.

ТУЗ-ийн гишүүд 2025 онд холбогдох 10 шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар засаглалын үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрээ үнэллээ:



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН СУРГАЛТ

ХасБанкны Засаглалын төлөвлөгөө 2023-2026-д тусгасны дагуу ТУЗ-ийн сургалтын хөтөлбөрийг “Дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал ба түүний Монголын эдийн засаг, банкы салбарт үзүүлэх нөлөө” сэдвээр 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ТУЗ-ийн ажлын алба Банк, Санхүүгийн Академитай хамтран цахимаар зохион байгууллаа.

Шинэ гишүүдийн тухайд, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг компанийн засаглалын сургалтад нэн тэргүүнд хамруулж (хэрэв энэ чиглэлээр аливаа сургалтад хамрагдаж байгаагүй бол) Монгол Улсын Компанийн тухай хууль, компанийн засаглалын онцлогийг таниулах сургалтыг зохион байгуулдаг.

Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход ХасБанкны багц баримт бичгүүд болох өмнөх оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлан болон бусад холбогдох бичиг баримтуудыг хүргүүлж танилцах боломжийг олгодог.

ТУЗ-ийн гишүүд нь Гүйцэтгэх захиралтай тохиролцон, Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүй байдлаар Банкны удирдлагуудтай уулзалт зохион байгуулж асууж тодруулах, мэдээлэл авах нөхцөл боломжоор хангагддаг.

9. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Аудитын хороо ("АХ")	Нэр дэвшүүлэх хороо ("НДХ")	Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ")	Засаглал, цалин урамшууллын хороо ("ЗЦУХ")
Дарга: Б.Уламбаяр (ХБ)	Дарга: Стюарт Холл (ХБ)	Дарга: Доминик Жак	Дарга: Майкл Мадден
Ердийн гишүүд: Анджей Витак Сюзанна Карр	Ердийн гишүүн: Сюзанна Карр Доминик Жак	Ердийн гишүүн: Майкл Мадден	Ердийн гишүүн: Н.Цэлмүүн
Хараат бус гишүүд: Нираж Вэдва Эми Чой Стюарт Холл	Хараат бус гишүүд: Б.Уламбаяр Нираж Вэдва Эми Чой	Хараат бус гишүүд: Б.Уламбаяр Нираж Вэдва Эми Чой Стюарт Холл	Хараат бус гишүүд: Б.Уламбаяр Нираж Вэдва Эми Чой Стюарт Холл

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь зургаа (6) буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь ТУЗ-ийн гишүүн байна.

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж буй гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дэргэдэх хороодод гишүүнээр ажилладаггүй.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг.

Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана.

ЗАСАГЛАЛ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (“ЗНДЦУХ”) нь Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн шийдвэрээр 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс чиг үүргийн дагуу “Нэр дэвшүүлэх хороо” болон “Засаглал, цалин урамшууллын хороо” хэмээх хоёр бие даасан хороонд хуваагдсан бөгөөд дараах үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Чиг үүрэг: ЗЦУХ нь компанийн засаглалын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, удирдлагын цалин хөлсний бүтэц, бодлогод хяналт тавих үүрэгтэй. Уг хороо нь Гүйцэтгэх захирал болон түлхүүр ажилтнуудын цалин урамшууллыг банкны стратегийн зорилт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны ашиг сонирхолд нийцүүлэх, банкны дотоод засаглалын тогтолцоо, эрх бүхий албан тушаалтны ёс зүй болон ашиг сонирхлын зөрчлийг удирдан хянах, холбогдох бодлого журам, үнэлгээ, сургалт, сайжруулалтын асуудлыг хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлага болон олон улсын сайн туршлагад нийцүүлэн хянах, ТУЗ-д санал, зөвлөмж хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Хорооны шинээр баталсан дүрэмтэй [ЭНД](#) дарж танилцана уу.

ХОРООНЫ ХУРАЛ

4

Нийт

3

Ээлжит хурал

1

Ээлжит бус хурал

26

Хэлэлцсэн асуудал

ЦАХИМ САНАЛ
ХУРААЛТ

1

Нийт

Засаглалын Кодексийн дагуу дараах бодлого, журмыг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг ТУЗ-д хүргүүлэв:

- ХасБанкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах: СЗХ-ны шаардлагын дагуу ЗНДЦУХ-ны чиг үүргийг хоёр тусдаа хороонд салган хуваарилах
- ХасБанкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах: Ахмадын сангийн зохицуулалт
- НДХ-ны дүрэм (Хороог хуваах асуудлыг хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд)
- ЗЦУХ-ны дүрэм (Хороог хуваах асуудлыг хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд)
- ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам ба холбогдох бусад дотоод дүрэм, журам (ЗНДЦУХ-г ЗЦУХ болон НДХ-нд хуваахтай холбогдуулан)
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт, өөрчлөлт оруулах: Насдак Платформ

Хурлын ирц (100%)

Майкл Мадден

100.00%

Н.Цэлмүүн

100.00%

Б.Уламбаяр

100.00%

Эми Чой

100.00%

Нираж Вэдва

100.00%

Стюарт Холл

100.00%

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Чиг үүрэг: НДХ нь ТУЗ-ийн бүрэлдэхүүний олон талт, үр нөлөөтэй байдлыг хангаж, удирдлагын залгамж халааг бэлтгэх асуудлаар ТУЗ-д дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Уг хороо нь ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд сонгогдон томилогдох мэргэжлийн ур чадварыг хангасан нэр дэвшигчдийг тодорхойлох, үнэлэх, санал болгох, түүнчлэн байгууллагын урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах үүднээс ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны төлөвлөлтийн талаар зөвлөмж, мэдээллээр хангах үндсэн үүрэг хариуцлагыг ханган ажиллаж байна.

Хорооны шинээр баталсан дүрэмтэй [ЭНД](#) дарж танилцана уу.

ХОРООНЫ ХУРАЛ

3 Нийт

2 Ээлжит хурал

1 Ээлжит бус хурал

14 Хэлэлцсэн асуудал

Нэр дэвшүүлэх хорооны хурлаар дараах асуудлуудыг тогтмол хэлэлцдэг:

- ТУЗ-ийн өөрийн болон ТУЗ-ийн гишүүний үнэлгээ
- Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн залгамж халааны төлөвлөгөө

Хурлын ирц (100%)

Стюарт Холл

100.00%

Нираж Вэдва

100.00%

Эми Чой

100.00%

Сюзанна карр

100.00%

Доминик жак

100.00%

Б.Уламбаяр

100.00%

ТУСГАЙ УУЛЗАЛТ

16 Цахим уулзалт

14 Ярилцлага

2 Дүгнэх уулзалт

Нэр дэвшүүлэх хороо 2025 онд Хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотойгоор нийт 16 удаагийн цахим уулзалт зохион байгуулсан. Үүнд, 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрийн хооронд олон улсын болон дотоодын нэр дэвшигчидтэй хийсэн 14 удаагийн ярилцлага, мөн ярилцлагын үр дүнг нэгтгэн дүгнэх 2 удаагийн уулзалт багтав.

Ярилцлагыг Нэр дэвшүүлэх хорооны гишүүд болон Сюзанна Карр, Нираж Вэдва, Б.Уламбаяр, Эми Чой, Стюарт Холл болон Албертус Браггинк нар явуулсан. Улмаар тус хороо ярилцлагын үр дүнг хэлэлцэн, жагсаалтад багтаах нэр дэвшигчдийг тодорхойлохоор дахин хуралдсан байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Чиг үүрэг: ЭУХ нь дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материаллаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг асуудлаар ТУЗ-д зөвлөх, түүнчлэн ТУЗ-өөс эрх шилжүүлсний дагуу зарим шийдвэр гаргах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай.

Хорооны шинээр баталсан дүрэмтэй [энд](#) дарж танилцана уу.

ХОРООНЫ ХУРАЛ

5 Нийт

4 Ээлжит хурал

1 Ээлжит бус хурал

34 Хэлэлцсэн асуудал

Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар дараах асуудлуудыг тогтмол хэлэлцдэг:

- ХасБанкны эрсдэлийн тайлан
- Комплаенсын явцын мэдээ/тайлан
- Зээлийн тойм
- Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах санал

ЦАХИМ САНАЛ ХУРААЛТ

19 Нийт

Хурлын ирц (100%)

Доминик Жак

Албертус Браггинк
2025.10.01-ний өдөр үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн.

Эми Чой

Майкл Мадден
2025.10.01-ний өдрөөс хойш гишүүнээр томилогдон ажиллаж байна.

100.00%

100.00%

100.00%

100.00%

Нираж Вэдва

Стюарт Холл

Б.Уламбаяр

100.00%

100.00%

100.00%

АУДИТЫН ХОРОО

Чиг үүрэг: Дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, ердийн бус хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. АХ нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг.

Хорооны шинээр баталсан дүрэмтэй [ЭНД](#) дарж танилцана уу.

ХОРООНЫ ХУРАЛ

5 Нийт

4 Ээлжит хурал

1 Ээлжит бус хурал

30 Хэлэлцсэн асуудал

Аудитын хорооны хурлаар дараах асуудлуудыг тогтмол хэлэлцдэг:

- Аудитын тайлан
- Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан
- Банкны холбогдох этгээдүүдийн улирлын тайлан (Монголбанкны журам)

Хурлын ирц (100%)

Б.Уламбаяр

100.00%

Нираж Вэдва

100.00%

Эми Чой

100.00%

Стюарт Холл

100.00%

Анджей Витак

100.00%

Сюзанна карр

100.00%

10. ЁС ЗҮЙН КОДЕКС, СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ БА ТОЛИЛУУЛГА

Банкны ёс зүйн хэм хэмжээ нь чин сэтгэлээсээ байх, үнэнч байх, шударга байх, ил тод байх зарчмуудад үндэслэдэг. ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан “ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд өөрийн холбогдох этгээдийн мэдээллийг өөрчлөлт орох тухай бүр мэдэгдэхээс гадна **жилд 2 удаа** бататгах толилуулгын хуудсыг үйлдэж, сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан тогтоох боломжийг ханган ажиллаж байна. Мөн түүнчлэн, ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхлын зөрчил байвал түүнийгээ мэдэгддэг ба Компанийн тухай хуулийн дагуу уг гишүүн санал хураалтад оролцдоггүй.

ХасБанк нь “Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам”-ыг баримтлан өөрийн ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлөөр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх, улмаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэн ажиллаж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нь холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлдэг.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

ХасБанк нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдэд зөвхөн харилцагчид санал болгох нөхцөлтэй ижил нөхцөлөөр үйлчилгээ үзүүлж байна.

Иймд, хэрэв тухайн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдэд болон олгосон нийт зээлийн хэмжээ 300.0 сая төгрөгөөс бага бол (орон сууцны зээлийн тухайд 200.0 сая төгрөгөөс бага бол) тухайн этгээдэд ердийн журмаар зээл олголт хийгдэх бөгөөд ийнхүү шийдвэрлэгдсэн хэлцлүүдийг улирал бүр ТУЗ хянан үзэж батламжилдаг. Харин, дээрх дүнгээс их, эсхүл харилцагчийн нөхцөлөөс өөр нөхцөлтэй тохиолдолд зөвхөн ТУЗ урьдчилан хянаж баталснаар үйлчилгээ үзүүлнэ.

ТУЗ-ийн эрсдэлийн удирдлагын хороо нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдийн хэлцэлд хяналт тавин, ТУЗ-өөр ийнхүү тухай бүр шийдвэрүүлдэг ба ингэхдээ, Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг баримтлан ажиллаж байна.


Тайлант хугацаанд батлагдсан сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийн жагсаалт

№	Хамаарал	Хэлцлийн дүн (төгрөг)
1	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
2	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
3	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
4	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
5	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
6	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	400,000
7	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	400,000
8	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	16,000,000
9	Банкны эрх бүхий албан тушаалтан	468,321,000
10	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	149,000,000
11	Банкны хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд	50,000,000
12	Банкны эрх бүхий албан тушаалтан	195,000,000


Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.

11. КОМПАНИЙН БҮТЭЦ

ХАСБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Тгэх захирал



12. УДИРДЛАГЫН БАГ



**Гүмэнжавын
Цэвэгжав**

Гүйцэтгэх захирал



**Ганзоригийн
Эрдэнэбаяр**

Гүйцэтгэх захирлын
тэргүүн орлогч бөгөөд
Иргэдийн банк
хариуцсан захирал



**Бавааны
Еркин**

Гүйцэтгэх захирлын
орлогч бөгөөд
Байгууллагын банк
хариуцсан захирал



**Серикжаны
Дауренбек**

Гүйцэтгэх захирлын
орлогч бөгөөд
Бизнесийн банк
хариуцсан захирал



**Доржпүрэвийн
Мөнхзул**

Лизинг
хариуцсан захирал



**Ганхуягийн
Тамир**

Санхүү хариуцсан
захирал



**Илия
Аврамов**

Эрсдэл хариуцсан
захирал



**Энхбаярын
Ундармаа**

Зээл хариуцсан
захирал



**Ганзоригийн
Зул**

Хүний нөөц, захиргаа
хариуцсан захирал



**Энэбишийн
Уламбаяр**

Үйл ажиллагаа
хариуцсан захирал



**Хүрэлбаатарын
Өнөрбат**

Мэдээллийн технологи
хариуцсан захирал



**Нямсүрэнгийн
Мөнхцэлмэг**

Хууль хариуцсан захирал
/ ТУЗ-ийн нарийн
бичгийн дарга



**Баттогтохын
Биндэрьяа**

Ерөнхий аудитор

Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал

Гүйцэтгэх захирлын цалин хөлс нь үндсэн цалин, жилийн гүйцэтгэлд суурилсан урамшууллаас бүрдэнэ. ТУЗ нь Гүйцэтгэх захирлын гэрээний нөхцөл болзол, Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн талаар гаргасан Засаглал, цалин урамшууллын хороо (хуучнаар ЗНДЦУХ. Тус хороо нь Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн шийдвэрээр 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр НДХ болон ЗЦУХ хэмээх хоёр бие даасан хороонд хуваагдсан болно.)-ны зөвлөмжийг үндэслэн Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлгээ хийдэг. Банкны стратегийн зорилго, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд тулгуурласан энэхүү үнэлгээ нь түүнд олгох цалин хөлсийг тодорхойлох үндэслэл болно.

Гүйцэтгэх захирлын 2025 оны ажлын гүйцэтгэлийг ТУЗ болон ЗЦУХ хэлэлцээд түүнд олгох 2025 оны гүйцэтгэлд суурилсан урамшууллыг баталсан¹.

¹ Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурын нэр төрөл нь байгууллагын нууц тул энд дэлгэрэнгүй тусгаагүй болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2026 оны 03 сарын 05 өдөр

№ R-2026-17

Улаанбаатар хот

2025 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны гүйцэтгэх удирдлага Банкны 2025 оны үйл ажиллагааны тайлан ("2025 оны үйл ажиллагааны тайлан")-г энэхүү тогтоолд хавсаргасан байдлаар бэлтгэснийг ТУЗ хянан хэлэлцээд, тус тайлан нь Банкны үйл ажиллагааны үр дүнг бодитоор ил тод илэрхийлсэн гэж дүгнэсэн ("ТУЗ-ийн дүгнэлт") болохыг тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны 2025 оны үйл ажиллагааны тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт Банкны хувьцаа эзэмшигчдэд өргөн мэдүүлэхээр баталсугай.
2. Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд 2025 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлтгэх, танилцуулах зэрэг энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГУПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn



Хурлаар шийдвэрлэх хоёрдугаар асуудал:

ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн
тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай



САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын хураангуй тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлан, өмчийн өөрчлөлтийн хураангуй тайлан, мөнгөн гүйлгээний хураангуй тайлангуудаас бүрдсэн Санхүүгийн хураангуй тайланг ХасБанк ХК ("Банк")-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу Банкны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын шаардсан бүх тодруулгуудыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан ба аудиторын дүгнэлт нь Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан аудитлагдсан санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд дараахыг багтаасан.

- Аудитын гол асуудал - Аудитын гол асуудал нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох "Зээлийн үнэ цэнийн бууралт" байсан.

Санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн хураангуй тайланг "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Банкны удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС") 810 буюу "Санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил"-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

Ernst & Young Mongolia Audit LLC



Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид
УЛААНБААТАР ХОТ

Гарын үсэг зурж баталсан:


Адриан Чу
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2026 оны 3 дугаар сарын 20

➤ **Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн

	2025 мян.төг	2024 мян.төг
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүү болон түүнтэй адилтгах орлого	841,642,694	703,265,483
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүү болон түүнтэй адилтгах орлого	12,754,214	12,974,358
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(536,698,331)	(396,254,799)
Хүүгийн цэвэр орлого	317,698,577	319,985,042
Хураамж ба шимтгэлийн орлого	48,706,882	44,072,758
Хураамж ба шимтгэлийн зардал	(18,766,059)	(15,935,071)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	29,940,823	28,137,687
Арилжааны цэвэр ашиг	16,491,643	15,983,088
БҮЦАА-д бүртгэсэн бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого	7,345,204	7,639,026
Үйл ажиллагааны бусад цэвэр орлого	22,646,970	10,962,475
Үйл ажиллагааны нийт орлого	394,123,217	382,707,318
Үнэ цэнийн бууралтын цэвэр (зардал)/буцаалт	(12,731,677)	2,129,641
Үйл ажиллагааны цэвэр орлого	381,391,540	384,836,959
Үйл ажиллагааны зардал	(159,399,655)	(154,856,979)
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	1,394,524	484,712
Татварын өмнөх ашиг	223,386,409	230,464,692
Орлогын татварын зардал	(50,790,225)	(58,784,404)
Тайлант жилийн ашиг	172,596,184	171,680,288
Бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):		
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:</i>		
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нөөцийн өөрчлөлт, татварын дараах	175,798	(856,106)
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах	175,798	(856,106)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	172,771,982	170,824,182
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):		
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	164.12	163.10
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	164.12	163.10

2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөн гарын үсэг зурав.


ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ
 (Гүйцэтгэх захирал)




ГАНХУЯГИЙН ТАМИР
 (Санхүү хариуцсан захирал)

Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан, Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

	2025 мян.төг	2024 мян.төг
ХӨРӨНГӨ		
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	238,239,937	33,914,061
Монголбанк дахь заавал байлгах нөөц	504,508,164	397,890,873
БУЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд		
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	46,166,061	10,050,723
Санхүүгийн хэрэгслүүд	147,862,972	112,300,780
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	165,355,679	209,855,668
БУЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө		
Өмчийн хэрэгслүүд	3,728,279	3,910,731
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө		
Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	443,313,886	776,096,768
Өрийн хэрэгслүүд	1,103,217,365	1,133,892,280
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,016,649,082	3,472,735,003
Бусад хөрөнгө	76,677,824	61,573,787
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	1,586,191	1,089,949
Үндсэн хөрөнгө ба ашиглах эрхтэй хөрөнгө	88,161,716	79,706,337
Биет бус хөрөнгө	14,741,075	16,833,961
Хойшлогдсон татварын хөрөнгө	11,684,447	11,942,798
НИЙТ ХӨРӨНГӨ	6,861,892,678	6,321,793,719
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
БУЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд		
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	6,812,173	9,542,837
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр		
Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж	3,074,022	276,333,956
Харилцагчдын харилцах, хадгаламж	3,749,383,957	3,424,786,562
Зээлээр авсан санхүүжилт	2,096,275,640	1,727,756,398
Хойшлогдсон нөхцөлт хандив	3,636,480	12,397,895
Түрээсийн өр төлбөр	11,380,292	7,233,884
Бусад өр төлбөр	125,146,763	105,974,775
Орлогын албан татварын өглөг	11,253,643	26,164,657
НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,006,962,970	5,590,190,964
ЭЗДИЙН ӨМЧ		
Энгийн хувьцаа	105,270,000	105,270,000
Халаасны хувьцаа	(267,282)	(29,668)
Нэмж төлөгдсөн капитал	28,513,791	30,388,871
Нөөцүүд	78,806,191	80,566,643
Хуримтлагдсан ашиг	642,607,008	515,406,909
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	854,929,708	731,602,755
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	6,861,892,678	6,321,793,719

2026 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөн гарын үсэг зурав.


ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ
 (Гүйцэтгэх захирал)



ГАНХУЯГИЙН ТАМИР
 (Санхүү хариуцсан захирал)

Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан, Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2026 оны 03 сарын 20 өдөр

№ R-2026-20

Улаанбаатар хот

2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны СТОУС болон НББОУС-ын дагуу бэлтгэсэн 2025 оны санхүүгийн тайланг Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК хянаж ("2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан") зөрчилгүй гэж дүгнэсэн болохыг;
2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо ("Аудитын хороо") 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит бус хурлаар хэлэлцээд 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан гэж үзэн батлах саналыг ТУЗ-д хүргүүлснийг; мөн
3. ТУЗ нь 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг энэхүү тогтоолын хавсралтад буй Аудиторын дүгнэлтийн хамт хянан хэлэлцээд тус тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан гэж дүгнэсэн ("ТУЗ-ийн дүгнэлт") болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталж Банкны хувьцаа эзэмшигчдэд танилцуулсугай.
2. Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав болон Санхүү хариуцсан захирал Г.Тамир нарт 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланд гарын үсэг зурах эрх олгосугай.
3. Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав болон Санхүү хариуцсан захирал Г.Тамир нарт 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлтгэх, танилцуулах зэрэг энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Мснгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Вэб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn



Хурлаар танилцуулах асуудал:

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ХҮРГЭХ ТАЙЛАН



2026 оны 4 дүгээр сарын 29-ний хувьцаа эзэмшигчдийн хуралд

ТУЗ-ийн хараат бус гишүүн Эми Чой ТУЗ-ийн бүх хараат бус гишүүдийг төлөөлөн тавих илтгэл

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хамт олон, зочид оо,

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн Та бүхэнд талархал илэрхийлье. Та бүхний ХасБанк дахь хөрөнгө оруулалтыг хамгаалах засаглалын тогтолцоо болон бидний хэрэгжүүлж буй үүрэг, хариуцлагын талаар тайлагнах боломж олдсонд бид баяртай байна.

1. Засаглалын хяналт

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хувьд бидний үндсэн үүрэг нь Та бүхэнд буюу хувьцаа эзэмшигчдийн өмнө байгууллагын урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэдэг. Бид банкны үйл ажиллагаанд хараат бус, бодитой дүгнэлт хийж, гүйцэтгэх удирдлагын баг стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн шаардлагад нийцэж ажиллах, эрсдэлийн чиглэлээр сахилга баттай байх үүргээ биелүүлэн ажиллаж буй эсэхэд хяналт тавьдаг.

2025 онд ХасБанк нь байгууллагын бүтэц, засаглалын тогтолцоонд стратегийн ач холбогдол бүхий шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж, аливаа этгээдийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцаа тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх Банкны тухай хуулийн шаардлагыг хангасан системийн нөлөө бүхий анхны банк болсон.

Мөн тус онд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор засаглалын тогтолцоонд шинэчлэл хийж, байгууллагын дотоод зохион байгуулалтыг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн шинэ түвшинд хүргэлээ. Үүнд:

- Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанктай амжилттай нэгтгэв.
- Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөмжийн дагуу Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог хоёр тусдаа хороо болгон (Засаглал ба цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо) хуваасан.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлийн үнэлгээний шинэ аргачлалыг баталсан.
- Дотоод 17 бодлого, журмыг шинээр баталж, шинэчилсэн.
- Банк болон жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох этгээдийн болон ашиг сонирхлын зөрчилтэй бүх хэлцлийг ТУЗ-өөр хянан хэлэлцэж баталсан.
- ТУЗ болон түүний хороод идэвхтэй ажиллаж, дараах байдлаар хуралдсан:

ТУЗ болон хороод	Нийт хурал	Онлайн санал хураалт	Баталсан тогтоол
ТУЗ	8	8	55
Эрсдэлийн удирдлагын хороо	5	19	-
Аудитын хороо	5	Байхгүй	-
Засаглал, цалин урамшууллын хороо	4	1	-
Нэр дэвшүүлэх хороо	3	Байхгүй	-

2. Стратегийн хэрэгжилт

- Стратегийн уялдаа: Банкны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, харилцагчийн сэтгэл ханамж, үнэнч байдлыг нэмэгдүүлэх, ажилтнуудын бүтээмж, сэтгэл ханамжийг дэмжих, хөрөнгө оруулагчдад тогтвортой өгөөж бий болгох, технологи болон кибер аюулгүй байдалд тасралтгүй хөрөнгө оруулах, мөн харилцагчийг таньж мэдэх, мөнгө угаахтай тэмцэх болон зээлийн чанарын хяналтыг сайжруулахад анхаарч ажилласан.
- Гүйцэтгэлийн хяналт: Дэлхийн болон дотоодын эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд ч гүйцэтгэх захирал болон түүний багийн гаргасан санхүүгийн үр дүнг өндрөөр үнэлж байна.

Цэвэр ашиг:	172.6 тэрбум төгрөг (+0.5% өмнөх оноос)
Чанаргүй зээл:	2.5% (салбарын хамгийн бага түвшний нэг)
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө:	20.1% (доод шаардлага 12.5%)
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар:	37.6% (доод шаардлага 25%)
Зээлийн багцын өсөлт:	+13.1%
Харилцах/хадгаламжийн өсөлт:	+9.4%

2025 онд харилцагчид чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт болон дижитал бүтээгдэхүүний нэвтрүүлэлтэд ахиц гарсан бөгөөд цаашид мөн сайжруулалтаа хяналттайгаар ахиулах шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн, дижитал шилжилт, олон нийтийн сүлжээ болон спортын арга хэмжээг дэмжих зэргээр брэндийг таниулах, байрлуулах ажлыг үргэлжлүүлэн тогтмол хөрөнгө оруулалт хийснээр зах зээл дэх байр сууриа бэхжүүлж байгааг харахад таатай байна.

3. Эрсдэлийн удирдлага ба хянан нийцүүлэлт

- Зээлийн эрсдэл: бид активын чанар болон активын эрсдэлийн сангийн нөөц хангалттай эсэхийг хянаж ажиллав.
- Үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлын эрсдэл: Дижитал орчинд банкны кибер аюулгүй байдлын тогтолцоог байнга сайжруулж буй эсэхэд хяналт тавьж байна.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэл: Санхүүгийн гэмт хэргийг үл тэвчих бодлогыг банк баримталдаг. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх банкны хяналтын тогтолцоо Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандарттай бүрэн нийцэж байна.

Банк эрсдэлийн хүлээн зөвшөөрөх зохих түвшингээ тодорхойлж түүнийгээ дагаж мөрддөгт бид сэтгэл хангалуун байна.

4. Аудит ба санхүүгийн үнэн зөв байдал

Бид дотоод аудитын нэгж болон хөндлөнгийн аудитортой нягт хамтран ажилласан. Жилийн санхүүгийн тайланг хянаж, банкны санхүүгийн байдал үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн гэж дүгнэсэн.

Мөн санхүүгийн болон санхүүгийн бус дотоод хяналтын тогтолцоо найдвартай байгаад сэтгэл хангалуун байна.

5. Дижитал ба мэдээллийн технологи

2025 онд ХасБанк харилцагчийг анх бүртгэхээс эхлэн хүрч үйлчлэх байдлыг сайжруулах, процессыг хялбаршуулах, онлайн автоматжуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр дижитал чадавхаа бэхжүүлсэн. Үүний хүрээнд, дижитал хэтэвчийг нэвтрүүлж төлбөрийн хялбар шийдлийг харилцагчиддаа санал болгож байна.

Нийцэл, эрсдэлийн удирдлага, засаглалын чиглэлээр мэдээллийн технологийн олон шинэ төслүүд хэрэгжүүлсэн. Мөн, кибер аюулгүй байдлын иж бүрэн аудитыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог улам бэхжүүлэхээр ажиллаж байна.

6. Дүгнэлт

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн зүгээс ХасБанкийг засаглалын хувьд төлөвшсөн, санхүүгийн хувьд тогтвортой, урт хугацаанд тогтвортой өсөлт хийх боломжтой байгууллага гэж үзэж байна.

Гүйцэтгэх захирал болон түүний багт бидэнтэй хамтран ажилладаг тань, мөн хувьцаа эзэмшигч Та бүхэнд итгэл хүлээлгэн дэмжиж ирсэнд тань баярлалаа. Түүнчлэн ТУЗ-ийн даргын манлайлалд баяр хүргэж, биднийг өнөөгийн түвшинд хүргэж, ирээдүйн сорилтуудыг даван туулах бэлтгэдэгт тань талархал илэрхийлье.

Баярлалаа!



Хурлаар шийдвэрлэх гуравдугаар асуудал:

ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах тухай




Агуулга

2025 оны 2-р хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах санал

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг болон ХасБанк ХК-ийн дүрмийн 8.6 (ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн R-2026-02 тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдэд дараах байдлаар ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр тараахыг санал болгож байна.

Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашиг	30.0 төгрөг
Ногдол ашгийн нийт дүн	31.5 тэрбум төгрөг
Ногдол ашиг тараах огноо	2026 оны 04-р сарын 30*: холбогдох бүх шийдвэр, зөвшөөрөл гарснаар
Ногдол ашиг тараах хэлбэр	ҮЦТХТ-өөр дамжуулан нэрийн дансаар
Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2026 оны 04-р сарын 14-ний өдрийг Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоох



Ногдол ашиг тараах хугацаа

2025 оны жилийн эцсийн татварын дараах цэвэр ашгаас хуваарилах ногдол ашиг

2026.02.16
ТУЗ-ийн шийдвэр

2026.04.23 **
Монголбанкны зөвшөөрөл

2026.04.29
Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр

Ногдол ашиг тараах огноо:
2026.04.30*

* Банк нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг тараалгахаар төлөвлөж байна.

** Банк нь ногдол ашиг тараах эсэх асуудалд зөвшөөрөл авахаар Монголбанкинд 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр холбогдох журмын дагуу хүсэлт гаргасан бөгөөд 60 хоногийн дотор Монголбанкнаас албан хариу авахаар тооцож байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2026 оны 02 сарын 16 өдөр

№ R-2026-02

Улаанбаатар хот

2025 оны жилийн эцсийн ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг болон ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 болон 46.8 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ нь татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор шийдвэрлэх шаардлагатай болохыг;
2. Банк нь аудитын байгууллагаар баталгаажуулсан 2025 оны хагас жилийн тайланд үндэслэн эхний хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18.00 (арван найм) төгрөг хуваарилсан болохыг;
3. Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2025 оны санхүүгийн жилийн эцсийн ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг ("Жилийн эцсийн ногдол ашиг") мөнгөн хэлбэрээр дорх дүнгээр хуваарилахыг ТУЗ-д санал болгосон ба хуваарилах ногдол ашгийн хэмжээ нь 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан гарсны дараа бүрэн баталгаажихыг; мөн
4. Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу ногдол ашиг хуваарилах эсэх нь Стратегийн асуудал бөгөөд хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэх тул ТУЗ нь 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээр баталгаажсан тохиолдолд дор дурдсан дүнгээр Жилийн эцсийн ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан Жилийн эцсийн ногдол ашигт нэгж хувьцаанд 30.00 (гучин) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчид Жилийн эцсийн ногдол ашиг зарлан хуваарилахаар баталсан тохиолдолд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("ХЭЭХ")-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг Жилийн эцсийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

3. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Жилийн эцсийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлж эхэлсүгэй. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолд заасны дагуу, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



Хурлаар шийдвэрлэх дөрөвдүгээр асуудал:

Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалтын танилцуулга



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2028 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ ХҮРТЭЛ ХУГАЦААНД БҮРЭН ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

ХасБанк ХК (“Банк”) нээлттэй хувьцаат компани болсноос хойш Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг 2 дахь удаа зохион байгуулах гэж байна. Компанийн тухай хуулийн 77.4 дэх хэсэгт зааснаар хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар, бүрэн бүрэлдэхүүнээр нь сонгоно.

Банкны Дүрмийн 8.16 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн бүрэн эрх 2 жилийн хугацаатай. Иймд 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон ТУЗ нь бүрэн эрхээ 2028 оны хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл хэрэгжүүлнэ.

Нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ийн хараат бус гишүүний 4 орон тоонд нийт 5 нэр дэвшигчийг Хувьцаа эзэмшигчдэд санал болгосон ба Монголбанк эдгээр бүх нэр дэвшигчид зохих зөвшөөрлийг олгосон болно.

Нэр дэвшүүлэх хороо нь мөн ТУЗ-ийн ердийн гишүүнд Санжай Гүпта болон Банкны Гүйцэтгэх Захирал Г.Цэвэгжав нарын 2 нэр дэвшигчийг нэр дэвшүүлсэн. Эдгээр 2 нэр дэвшигчид МонголБанк зохих зөвшөөрлийг олгосон болно. Түүнчлэн, Хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгох 6 нэр дэвшигчийг нэр дэвшүүлсэн бөгөөд эдгээр нэр дэвшигчид хурлын материалыг нийтэд ил болгох өдрийн байдлаар Монголбанкны зөвшөөрөл хараахан ирээгүй байна.

Ийнхүү, нэр дэвшигчдийн жагсаалтад хараат бус гишүүний 4 орон тоонд нэр дэвшиж буй 5 нэр дэвшигч, ердийн гишүүний 8 орон орон тоонд нэр дэвшиж буй 8 нэр дэвшигч буй болно.

Хувьцаа эзэмшигчид нь тогтоолоор: (i) шинэ ТУЗ-ийг бүрдүүлэх 12 гишүүнийг сонгох, (ii) одоогийн ТУЗ болон ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсныг хүлээн зөвшөөрөх, мөн (iii) Албертус Браггинкийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх асуудлаар шийдвэр гаргана. ТУЗ-ийн гишүүн Браггинк нь өөрийн хүсэлтээр 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн. ТУЗ нь ТУЗ-ийн гишүүн Албертус Браггинкийн хүсэлтийг хүлээн авч, 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн R-2025-42 дугаар тогтоолоор түүнийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсөн юм.

Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчид

#	Нэр	Нэр дэвшиж буй албан тушаал	ТУЗ-д ажилласан жил
1	Эми Чой	ТУЗ-ийн хараат бус гишүүн	3 жил
2	Брэд Жонс	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Шинэ нэр дэвшигч
3	Нираж Вэдва	ТУЗ-ийн хараат бус гишүүн	8 жил
4	Оюунбилэг Эрэндоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Шинэ нэр дэвшигч
5	Стюарт Доналд Холл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2 жил



ЭМИ ЧОЙ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл

Мэдээллийн системийн шинжилгээ, бизнесийн шинжилгээ

Санхүүгийн зах зээлд

тасралтгүй ажилласан туршлага 41 жил

Боловсрол

Хонконгийн Политехникийн Их Сургууль, Мэдээллийн системийн шинжилгээ ба дизайны чиглэлээр ахисан түвшний диплом

Лондонгийн Сити Их Сургууль Бизнесийн шинжилгээ, дизайны чиглэлээр шинжлэх ухааны магистр

Ажлын туршлага

1982-1993	Хонконг дахь АйБиЭм Банк, Системийн инженер, Ахлах инженер, Санхүүгийн үйлчилгээний систем хариуцсан менежер (Даатгалын автоматжуулалт болон Банкны үйл ажиллагаа)
1994-2010	Ситибанк Хонг Конг, Салбарын менежер, Олон улсын хувийн банк хариуцсан албаны захирал, Ерөнхий захирал (Салбарын борлуулалт, түгээлт)
2010-2013	Хятадын Гуангфа Банк, Иргэдийн банк хариуцсан гүйцэтгэх дэд ерөнхийлөгч
2013-2017	Пинг Ань Банк, Иргэдийн банк хариуцсан дэд ерөнхийлөгч
2017-2020	Хятадын Зүүн Азийн Банк, Гүйцэтгэх захирлын орлогч
2023 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн



БРЭД ЖОНС

Боловсрол

Худалдааны бакалавр, Гриффит Их Сургууль

Бизнесийн удирдлагын мэргэжлийн диплом,
Квийнслэндийн Их Сургууль

Санхүүгийн технологийн магистр, Нью Саут
Уэльсийн Их Сургууль

Ажлын туршлага

2001-2005	Эй Эн Зи Банк, Мельбурн, Австрали - Төслийн менежер
2005-2007	Эй Эн Зи Банк, Мельбурн, Австрали - Олон улсын түншлэл хариуцсан үйл ажиллагааны хэлтсийн дарга
2007-2010	Уинг Камбож (Эй Эн Зи Банк) - Гүйцэтгэх захирал
2010-2012	Виза - Дижитиал инноваци хариуцсан захирал
2012-2013	Олон улсын санхүүгийн корпораци (Дэлхийн Банк) - Зөвлөх
2013-2015	Австралийн Үндэсний Банк - Ази Тивийн өөрчлөлт хариуцсан захирал
2014-2016	Ферст Финанс Камбож - ТУЗ-ийн гишүүн, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга
2015-2023	Вэйв Мони - Гүйцэтгэх захирал
2018-2020	Теленор Мьянмар - ТУЗ-ийн гишүүн
2018-2023	Мьянмар дахь Австрали Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим - ТУЗ-ийн гишүүн
2023-2025	Эйч Эс Би Си, ПэйМи - Гүйцэтгэх захирал
2025 оноос	Яс Миксс Танзани - ТУЗ-ийн гишүүн



НИРАЖ ВЭДВА

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл

Мэдээллийн технологи, худалдаа, бизнес

Санхүүгийн зах зээлд

тасралтгүй ажилласан туршлага 32 жил

Боловсрол

Дели Их Сургууль, Эдийн засгийн чиглэлээр бакалавр
Индира Гандигийн нэрэмжит Их Сургууль, Худалдаа, маркетингийн чиглэлээр магистр

Ажлын туршлага

1989-1994	Нэтворк Лимитед компани, Дүүргийн худалдааны менежер
1994-1997	ТиЭнТи Экспресс, Хойд Энэтхэг, Балба бүсийн худалдааны менежер
1997-1999	Модикорп компани, Дотоод худалдааны менежер,
1999-2011	Нуклеус Софтвэр, Үйл ажиллагаа хариуцсан захирал
2011-2013	Тек Махиндра, Банк, төлбөр тооцоо, карт олон улсын хэмжээнд хариуцсан захирал
2013-2019	Тек Махиндра, Олон улс хариуцсан менежер
2018 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн
2019 оноос	Акселерик Эф Зи компанийн Гүйцэтгэх захирал



ЭРЭНДООГИЙН ОЮУНБИЛЭГ

Боловсрол

Мэргэжлийн диплом, Америкийн банкны холбооны дэргэдэх Стониер банкны сургууль

Бизнесийн удирдлагын магистр, СЭЗИС, Монгол Улс

Олон улсын харилцааны эдийн засагч, ЛенинГрад их сургууль, ОХУ

Ажлын туршлага

2003-2013	ХААН Банк – Дэд захирал болон ТУЗ-н нарийн бичгийн дарга
2001-2003	Хөдөө аж ахуйн банкиг эрүүлжүүлэх төсөл - Зохицуулагч
2016-2021	Петровис Ойл ХХК - Засаглал, комплайнс эрхэлсэн захирал; Петровис Групп -ТУЗ-н нарийн бичгийн дарга
2014-2021	ОУСК - Зөвлөх; 2024 оноос хойш Ази, Номхон далайн бүсийн төслүүд дээр гэрээгээр ажиллаж эхэлсэн
2010 оноос	Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ - Сургагч багш
2015 оноос	МИК ТЗК - ТУЗ-ийн хараат бус гишүүн
2021-2024	Пи Эм Ай Монголиа Чаптер - гишүүнчлэл хариуцсан захирал
2021 оноос	Агула Даатгал - ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга
2022 оноос	Монложистикс Холдинг - ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн хорооны дарга
2025 оноос	Төслийн удирдлагын институт - 9-р бүсийн ментор /Япон, Хонконг, Тайван, Өмнөд Солонгос, Монгол улсын Пи Эм Ай Чаптерыг хариуцна/



СТЮАРТ ХОЛЛ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, цалин урамшууллын хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл

Санхүү, Нягтлан бодох

Санхүүгийн зах зээлд
тасралтгүй ажилласан туршлага 43 жил

Боловсрол Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльсийн Их Сургууль, Худалдааны бакалавр
Австралийн Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт, Мэргэжлийн практик сургалтын хөтөлбөр

Ажлын туршлага

1883-1985	Туш Росс энд Ко, Мэргэшсэн нягтлан бодогч
1985-1986	Фокс Ассошиэт, Мэргэшсэн нягтлан бодогч
1886-1994	Американ Экспресс Банк, Захирал
1994-2013	Стандарт Чартеред Банкны Индонез, Сингапур, Филиппин, Вьетнам, Өмнөд Солонгос болон Лондон дахь салбар, Удирдах албан тушаал
2013-2017	ДиЖейЭм Капитал Лимитед, ТУЗ-ийн дарга
2018-2021	Индонез Улс дахь Катарын Үндэсний Банк, Зөвлөх болон Гүйцэтгэх захирал
2022-2025	Пиур Фүүд Аллианс, ТУЗ-ийн гишүүн
2024 оноос	Графаит Өэрт, ТУЗ-ийн гишүүн
2024 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээс бусад гишүүнд нэр дэвшигчид

#	Нэр	Нэр дэвшиж буй албан тушаал	ТУЗ-д ажилласан жил	Нэр дэвшүүлж буй этгээд
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн гишүүн	9 жил	Нэр дэвшүүлэх хороо
2	Ашот Осипян	ТУЗ-ийн гишүүн	Шинэ нэр дэвшигч	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)
3	Баатарын Батсайхан	ТУЗ-ийн гишүүн	2014-2016 хооронд 2 жил ажилласан	Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди
4	Мелисса Мой Тиен	ТУЗ-ийн гишүүн	2019-2021 хооронд 2 жил ажилласан	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)
5	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	17 жил	Ронок Партнерз Кей Эф Ти
6	Сюзанна Карр	ТУЗ-ийн гишүүн	4 жил	Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)
7	Нямтайширын Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	14 жил	МАК Инвест Эс Жи Пи Ти И Эл Ти Ди
8	Гүмэнжавын Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн	7 жил	Нэр дэвшүүлэх хороо



САНЖАЙ ГҮПТА

ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн дарга нь ХасБанкны толгой компани ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (ТСН)-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байсантай холбоотойгоор хараат бус гишүүнд тооцогддоггүй боловч ХасБанкны аль нэг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс хамааралгүй гишүүн болно.

Мэргэшсэн чиглэл

Эдийн засаг, санхүү

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага

45 жил


Боловсрол

Дели дэх Сэинт Стивинг коллеж, Физикийн шинжлэх ухааны бакалавр

Дели Их Сургуулийн Менежментийн факультет, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага

1981-2001	БНЭУ, Англи болон ХонгКонг дахь Америкийн Банк, Байгууллагын банк хариуцсан захирал (Энэтхэг); Байгууллагын санхүүжилт хариуцсан захирал (Энэтхэг); Санхүүгийн байгууллага хариуцсан захирал (Энэтхэг); Европ, Ойрх Дорнод, Африкийн (ЕОДА) орнуудад Гүйцэтгэх захирал болон Эрсдэлийн удирдлага хариуцсан захирал; ЕОДА-ийн Стракчард Кредит Группийн Гүйцэтгэх захирал; Ази дахь Инвестмент Банкинг Группийн Гүйцэтгэх захирал
2001-2005	Кредит Лионасс Ази, Номхон далайн бүс, Зээл хариуцсан захирал
2006-2015	Кредит Агриколь Групп, Ази дахь зээлийн дахин санхүүжилт хариуцсан захирал, Глобал Энержи Групп, Ази хариуцсан захирал
2017-2019	ТСН ХХК, ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2019-2025	ТСН ХХК, ТУЗ-ийн дарга (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2019 оноос	ХасБанкны ТУЗ-ийн дарга



АШОТ ОСИПЯН

Боловсрол

Барилгын эдийн засаг, менежмент,
Архитектур болон барилгын Ереваны улсын
их сургууль

Магистр, Бүгд Найрамдах Армени Улсын
Шинжлэх Ухааны Үндэсний Академийн
Эдийн засгийн хүрээлэн

Хурдасгасан хөгжлийн хөтөлбөр, Чикагогийн
Бизнесийн сургууль

Ажлын туршлага

1994-1998	Сангийн яам, Армени Улс - Үнэт цаасны зах зээлийн хяналтын газрын дарга, Ахлах эдийн засагч; Мөнгөний бодлогын газрын дарга, Санхүүгийн бодлогын ерөнхий газрын дарга
1998-2006	Армекономбанк нээлттэй ХК - Гүйцэтгэх зөвлөлийн дарга
2006-2019	Араратбанк нээлттэй ХК - Гүйцэтгэх зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал
2011-2013	Бүгд Найрамдах Армени Улсын Банкуудын Холбоо - ТУЗ-ийн дарга
2020-2023	Эсхата Банк нээлттэй ХК, Таджикистан - Хяналтын зөвлөлийн гишүүн, Эрсдэлийн удирдлага болон Комплаенсийн Хорооны дарга (ЕСБХБ-наас нэр дэвшүүлснээр)
2022 оноос	Асакабанк ХК, Узбекистан - Стратеги болон хөрөнгө оруулалтын хорооны дарга (Бүгд Найрамдах Узбекистан Улсын Сангийн яамнаас нэр дэвшүүлснээр)
2025 оноос	Байлик Файнанс, Бүгд Найрамдах Киргиз Улс - Хяналтын зөвлөлийн гишүүн, Аудитын хорооны дарга
2025 оноос	Асакабанк ХК, Узбекистан - Хяналтын зөвлөлийн дарга



БААТАРЫН БАТСАЙХАН

Боловсрол

Эдийн Засгийн Бакалавр, Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар

Маркетинг ба Өрсөлдөөний стратегийн Бакалавр, Хитоцубаши Их Сургууль, Токио

Ажлын туршлага

2000-2002	А.Т Кеарни, Токио, Япон Улс - Менежментийн зөвлөх
2002-2003	Юникло Жижиглэн Худалдаа, Токио, Япон Улс - Идэвхжүүлэлтийн хэлтсийн менежер
2004-2008	М-Си-Эс Групп - Дэд ерөнхийлөгч
2005-2008	ГОЁО Кашмер - Гүйцэтгэх Захирал
2007 оноос	Санаа Партнерс - Захирал
2010 оноос	Монголиа Оппортунюитис Фанд - Хамтран үүсгэн байгуулагч, Захирал



МЕЛИССА МОЙ ТИЕН

Боловсрол

Шинжлэх ухааны бакалавр, Нью-Йоркийн Их Сургууль, Нью Йорк

Бизнесийн удирдлагын магистр, Колумбын Бизнесийн Сургууль, Нью Йорк

ТУЗ-ийн гишүүний диплом, Файненшл таймс, Хонконг

Ажлын туршлага

1988-1991	Дон & Брэдстрийт Корпорац, Нью-Йорк болон Парис, Дотоод аудитын газар - Аудитор
1993-2000	Ситигрупп, Нью-Йорк - Олон улсын химийн болон эмийн үйлдвэрлэлийн салбарын Дэд ерөнхийлөгч
2001-2010	Эйч Эс Би Си Холдингз ПиЭлСи Нью-Йорк - Ахлах дэд ерөнхийлөгч, Төрөлжсөн үйлдвэрлэлийн групп, Химийн салбар Хонконг - Олон улсын банкны удирдлагын албаны захирал
2010-2018	Жэй Пи Морган Нью-Йорк - Ази, Ойрхи Дорнодын бүс хариуцсан захирал, Олон Улсын Байгууллагын Банк Хонконг - Хонконг хариуцсан захирал, Олон Улсын Байгууллагын Банк
2019-2021	ХасБанк ХК - ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны дарга
2020 оноос	Оксфам, ХонКонг - Санхүү, Эрсдэл болон Аудитын хорооны гишүүн
2021-2025	Эйч Эс Би Си Холдингз ПиЭлСи, Хонконг, Лондон - Олон улсын банк болон зах зээл хариуцсан Гүйцэтгэх захирлын Тэргүүн зөвлөх
2022-2025	Эйч Эс Би Си Инвестмент Банкинг Холдингс, Лондон - ТУЗ-ийн гишүүн
2023 оноос	Пентагрийн Капитал (Эйч Эс Би Си болон Темасек-ийн хөрөнгө оруулалттай компани), Сингапур - ТУЗ-ийн гишүүн, Зээлийн хорооны гишүүн



МАЙКЛ МАДДЕН

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, цалин урамшууллын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Ронок Партнерз Кэй Эф Ти компаниас нэр дэвшүүлсэн

Мэргэшсэн чиглэл

Санхүү, хөрөнгө оруулалт

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага

30 гаруй зах зээлд 36 жилийн туршлагатай

Боловсрол

Ирланд улс, Менежментийн Судалгааны Коллеж, Аж үйлдвэрийн инженерийн чиглэлээр диплом

Компанийн засаглалын хөгжлийн төв, Компанийн засаглалын гэрчилгээ

Ажлын туршлага

1993-2003	Американ Экспресс санхүүгийн байгууллагын Ирланд, Их Британи болон ОХУ дахь салбар, Удирдах албан тушаал
2003-2007	Банк Ренесанс Кредит, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
2007 оноос	Ронок компани (шинэ зах зээлийн хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээ), Үүсгэн байгуулагч, Удирдах түнш
2009-2025	ТСН ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн (ХасБанкинд нэгтгэсэн)
2011-2024	Тенео, ТУЗ-ийн дэд дарга; Капитал Адвайзори, ТУЗ-ийн дарга
2009 оноос	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2015 оноос	Ронок Азия ПиТиИ ЭлТиДи, ТУЗ-ийн дарга
2024 оноос	Конселло Групп, Партнер



СЮЗАННА КАРР

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, Олон Улсын Санхүүгийн Корпорациас нэр дэвшүүлсэн

Мэргэшсэн чиглэл

Хөрөнгө оруулалт, санхүү

Санхүүгийн зах зээлд

тасралтгүй ажилласан туршлага

39 жил

Боловсрол

АНУ, Дьюкийн Их Сургууль, Эдийн засгийн бакалавр

Ажлын туршлага

1987-1993	АНУ-ын Филадельфия, Пенсильвания муж дахь Фёрст Фиделити Банк Корпорейшн/СМС Компаниуд, Хөрөнгө оруулалтын банкир
1994-1995	Варшав, Польш, АНУ дахь Эв Санааны Нэгдэл Үйлдвэрчний Эвлэл/Энх тайвны Корпус, Бизнесийн зөвлөх
1996-2019	Вашингтон хотын Дэлхийн Банкны Группын гишүүн; Олон Улсын Санхүүгийн корпораци, Зээлийн багц, бодлого ба технологи хариуцсан удирдах албан тушаал
2018-2023	Люксембургийн Бичил санхүүгийн хөгжлийг дэмжих сан, ТУЗ болон Хөрөнгө оруулалтын хорооны гишүүн
2020-2024	ПроКредит Банк, Белград, Серб улс, ТУЗ-ийн гишүүн
2021-2022	Дэлхийн Банкны Хараат бус үнэлгээний групп, Зөвлөх
2022-2025	ТСН ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2022 оноос	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2024 оноос	Трипл Жампын Хөрөнгө оруулалтын комиссын гишүүн



НЯМТАЙШИР ЦЭЛМҮҮН

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, цалин урамшууллын хорооны гишүүн, МАК Инвест ЭсЖи ПиТиИ ЭлТиДи компаниас нэр дэвшүүлсэн

Мэргэшсэн чиглэл

Хөрөнгө оруулалт, бизнес

Санхүүгийн зах зээлд

тасралтгүй ажилласан туршлага 21 жил

Боловсрол

АНУ-ын Индиана мужийн Вальпараисо Их Сургууль, Бизнесийн удирдлага чиглэлээр бакалавр

ХонгКонгийн Стэнфордын Их Сургууль, Харвардын Бизнесийн сургууль, Санхүүгийн инженерчлэлийн чиглэлээр гэрчилгээ

Ажлын туршлага

2005-2007	Худалдаа хөгжлийн банк, Төслийн Санхүү хариуцсан менежер
2007-2010	Монголын Алт ("МАК") ХХК, Ахлах мэргэжилтэн
2010-2012	Монголын Алт ("МАК") ХХК, Худалдаа болон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн газрын захирал
2012-2016	Монголын Алт ("МАК") ХХК, Худалдаа, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд ерөнхийлөгч, Бодлогын зөвлөлийн гишүүн
2012-2025	ТСН ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2012 оноос	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2016 оноос	Монголын Алт ("МАК") ХХК, Ерөнхийлөгч/ Гүйцэтгэх захирал
2018-2024	Премиум Бюлдинг Материалс, ТУЗ-ийн гишүүн



ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ

ТУЗ-ийн гишүүн бөгөөд Гүйцэтгэх захирал

Мэргэшсэн чиглэл

Банк, санхүү

Санхүүгийн зах зээлд

тасралтгүй ажилласан туршлага 22 жил

Боловсрол

АНУ-ын Колорадогийн Их Сургууль, Бакалавр

Рэжис Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага

2004-2008	АНУ дахь Уагнер Экьюпмент, Санхүү/Хөрөнгийн шинжээч, Олон улсын нягтлан бодогч
2008-2010	Сан Франциско хот дахь Рэсторэйшн Хардвэйр компани, Хөрөнгө зохицуулалтын менежер; Блүфин Ассосиетс (Пламслийс) компани, Санхүү хариуцсан захирал
2011-2019	ХасБанк, Иргэдийн банк хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал, ХасЛизинг ХХК, Гүйцэтгэх захирал, Тэнгэр Даатгал ХХК, ТУЗ-ийн дарга, Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д Санхүү хариуцсан захирал
2019-2025	ТСН ХХК, Гүйцэтгэх захирал (ХасБанкинд нэгтгэж, үйл ажиллагаа дуусгавар болсон)
2019 оноос	ХасБанкны Гүйцэтгэх захирал болон ХасБанкны ТУЗ-ийн гишүүн



Хурлаар шийдвэрлэх тавдугаар асуудал:

ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай



ТУЗ-ИЙН 2026 ОНЫ ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ

ХасБанкны Дүрмийн 8.6(v) дахь заалтад зааснаар ТУЗ-ийн төсвийг хувьцаа эзэмшигчид баталдаг. Иймд хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр ХасБанкны ТУЗ-өөс 2026 оны төсвийг өмнөх оны адилаар 7,250 сая төгрөгийн дүнтэйгээр оруулж байна.

ТУЗ-ийн төсөв 2025 онд 7,250 сая төгрөгөөр батлагдаж байсан бөгөөд бодит гүйцэтгэл 6,778 сая төгрөг байв.

ТУЗ-ийн төсөв нь (i) хөлс, нэмэгдэл, урамшуулал (үүнд ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн хөлс, нэмэгдэл, урамшуулал багтах ба гүйцэтгэх захирал ТУЗ-ийн гишүүнээр ажилласныхаа төлөө аливаа, хөлс, нэмэгдэл, урамшуулал авдаггүй); (ii) бусад зардал (үүнд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, зорчих болон буудаллах зардал, ТУЗ-ийн болон хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах зардал, ТУЗ-д үйлчилгээ үзүүлэх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын үйлчилгээний төлбөр зэрэг) багтана.

	2025 оны төсөв	2025 оны гүйцэтгэл	2026 оны төсөв
Дүн (сая төгрөгөөр)	7,250.8	6,778	7,250.8

Улаанбаатар хот

ХАСБАНК

Н.МӨНХЦЭЛМЭГ

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 05-ны өдрийн Р-2026-14 дүгээр тогтоолын Хавсралт



**ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2026 ОНЫ ТӨСӨВ**
(Банкны Хувьцаа эзэмшигчдээр батлуулах)

Д	Зориулалт	Дүн төгрөгөөр (сая)
1	Цалин урамшуулал ¹	5,523.0
2	Бусад зардал	1,727.7
	Нийт дүн	7,250.8

-oOo-

¹ Цалин урамшуулал гэдэгт хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор баталсан ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, мөн хүчин төгөлдөр Гэрээний нөхцөлд заасан ТУЗ-ийн даргын цалин урамшууллыг ойлгоно.



**Хувьцаа эзэмшигчдийн
хурлын тогтоолын төслүүд**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл-1]

2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("**Банк**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("**ТУЗ**") 2025 оны үйл ажиллагааны тайлан ("**2025 оны үйл ажиллагааны тайлан**")-г хянан хэлэлцээд 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2026-17 тоот тогтоол гарган, 2025 оны үйл ажиллагааны тайлан нь Банкны үйл ажиллагааны үр дүнг бодитоор материаллаг алдаагүй илэрхийлсэн гэж дүгнэж ("**ТУЗ-ийн дүгнэлт**"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны 2025 оны үйл ажиллагааны тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл-2]

2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн
талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК ("**Банк**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийн зөрчилгүй гэж нягтлан баталгаажуулсан Банкны 2025 оны санхүүгийн тайлан ("**2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан**")-г Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("**ТУЗ**") хянан хэлэлцээд, тус тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу үнэн зөв, бодитоор тайлагнасан гэж 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-20 дугаар тогтоолоороо дүгнэн ("**ТУЗ-ийн дүгнэлт**"), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл-3]

Банкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас
ногдол ашиг зарлан хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6(ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Ногдол ашиг хуваарилах эсэх нь Банкны Дүрэмд заасан стратегийн асуудал тул Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал эцэслэн батлах шаардлагатай болохыг;
2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан, Банкны 2025 оны цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах ("Жилийн эцсийн ногдол ашиг")-ыг 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн R-2026-02 дугаар тогтоолоор Хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;
3. ТУЗ нь 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-20 дугаар тогтоолоор 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг баталсан бөгөөд тус тайлан аливаа материаллаг өөрчлөлтгүйгээр батлагдсан болохыг; мөн
4. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс санал болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Жилийн эцсийн ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Жилийн эцсийн ногдол ашигт нэгж хувьцаанд 30.00 (гуч) төгрөг зарлан хуваарилсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийг Жилийн эцсийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү тогтоол батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор Жилийн эцсийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолд заасны дагуу, Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь банкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх Банкны ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, түүний залгамж халааг бэлдэх ерөнхий журмын 2.2.4 дэх заалт, 6.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу, Нэр дэвшүүлэх хороо ("НДХ") нь Банкны хувьцаа эзэмшигчдэд (i) ТУЗ-ийн хараат бус гишүүний дөрвөн (4) орон тоонд таван (5) нэр дэвшигч; (ii) ердийн гишүүний найман (8) орон тоонд хоёр (2) нэр дэвшигчийг нэр дэвшүүлсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдээс ердийн гишүүнд зургаан (6) нэр дэвшигчийг нэр дэвшүүлснийг;
2. Банкны Дүрмийн 8.16 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн бүрэн эрх 2 жилийн хугацаатай бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн SR-2024-10 дугаар тогтоолоор сонгогдсон одоогийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа нь Банкны хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал дууссанаар дуусгавар болохыг;
3. ТУЗ 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн R-2025-42 дугаар тогтоолоор ТУЗ-ийн ердийн гишүүн Албертус Браггинкын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлаар шийдвэрлүүлэхээр тогтоосныг; мөн
4. Хувьцаа эзэмшигчид нь кумулятив аргаар хураасан санал хураалтын үр дүнг тодорхойлсон Тооллогын комиссын шийдвэрт үндэслэн, дараах нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдээр сонгохыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Дараах нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал дуусгавар болох үеэс Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал дуусгавар болох хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдээр сонгосугай:

(i)ТУЗ-ийн хараат бус гишүүний орон тоонд:

- 1.[***];
- 2.[***];
- 3.[***]; мөн
- 4.[***].

(ii)ТУЗ-ийн ердийн гишүүний орон тоонд:

1.[***];

2.[***];

3.[***];

4.[***]

5.[***];

6.[***];

7.[***]; мөн

8.[***].

2. Хувьцаа эзэмшигчид Албертус Браггинкын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөр хүлээн авсанд тооцсугай.
3. Одоогийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацааг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал дуусгавар болох үеэс дууссанд тооцсугай.
4. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлж, энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай эсхүл зохих арга хэмжээ авч ажиллахыг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт даалгаж, холбогдох эрхийг олгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл-5]

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.4 дэх хэсэг болон 8.6(v) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2026-14 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн 2026 оны төсөв ("ТУЗ-ийн 2026 оны төсөв")-ийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг дурдав.

ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн 2026 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

**ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2026 ОНЫ ТӨСӨВ**

Хавсралт

Д	Зориулалт	Дүн төгрөгөөр (сая)
1	Хөлс ¹	5,523.00
2	Бусад зардал	1,727.8
	Нийт дүн	7,250.8

-oOo-

¹Хөлс гэдэгт хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор баталсан ТУЗ-ийн гишүүдийн хөлс, нэмэгдэл, мөн ТУЗ-ийн даргатай байгуулсан хүчин төгөлдөр хөлсөөр ажиллах гэрээний нөхцөлд заасан ТУЗ-ийн даргын хөлс, урамшууллыг ойлгоно.



**Тооллогын комиссын
бүрэлдэхүүн**

ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн
R-2026-21 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

Комиссын дарга: Б.Ананд, Гүйцэтгэх захирал, Нөхөрлөлийн гишүүн, Кэй И Партнерс ХХН

Комиссын гишүүд: М.Лхамсүрэн, Нөхөрлөлийн гишүүн, Кэй И Партнерс ХХН

Г.Хажидмаа, Эрх зүйч, Кэй И Партнерс ХХН



Саналын хуудасны загварууд

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР №1

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн
R-2026-21 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт



ЕРДИЙН ЖУРМААР ӨГӨХ САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	☐	☐	☐
2.	ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	☐	☐	☐
3.	ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах	☐	☐	☐
4.	ТУЗ-ийн 2026 оны төсөв	☐	☐	☐

Хувьцаа эзэмшигчдийн хуралд тавих асуулт болон санал

*Цаг хугацааны бололцоог харгалзан, хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн зарим асуулт, саналыг ээлжит хурлын үеэр танилцуулж, хариулт өгч болно. Ийнхүү хэлэлцэх нь урьдчилан ирүүлсэн саналд гагцхүү хамаарахыг анхаарна уу. Хуралд биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчид нь хурлын үеэр асуултаа шууд тавих боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн (үнэт цаасны компани) _____

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

_____ / _____

2026 оны ... сарын ...-ны өдөр



КУМУЛЯТИВ АРГААР ӨГӨХ САНАЛ ХУРААЛТЫН ХУУДАС

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Тайлбар/Санамж:

Таны өгөх нийт саналын тоо нь бүртгэлийн өдрөөр таны эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-ийн нийт гишүүдийн тоо¹ буюу Банкны Дүрмийн дагуу 12-оор үржүүлж тооцогдоно. ТУЗ-ийн 12 гишүүний 8 нь ердийн, 4 нь хараат бус гишүүдээс бүрдэнэ.

Томьёо:

$$\text{Саналын эрхийн тоо} = \text{Бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй таны хувьцааны тоо} \times 12$$

Хувьцаа эзэмшигч нь саналаа ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх боломжтой. Энэхүү арга нь хувьцаа эзэмшигч өөрийн хүсэл зоригоор нэг эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид саналаа төвлөрүүлэн өгөх боломжийг олгодог.² Санал хураалтын үр дүнд хамгийн олон санал авсан нэр дэвшигчид нь ТУЗ-ийн гишүүдээр сонгогдоно. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолно. Энэ нь ердийн гишүүнд нэр дэвшигчдийг хооронд нь жагсаан, эрэмбэлэх арга бөгөөд хамгийн олон санал авсан найман нэр дэвшигч ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдоно. Үүний адилаар, хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг мөн хооронд нь жагсаан эрэмбэлж, хамгийн олон санал авсан дөрвөн нэр дэвшигч ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдоно.

Саналаа хуваарилан өгөх жишээ:

Хувьцаа эзэмшигч А нь ХҮ ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 12 гишүүнтэй, үүнээс 4 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ.

¹ Компанийн тухай хуулийн 72.1.3 дахь заалт; СЗХ-ны Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам (СЗХ-2020/09/09 #880)-ын 2.1 дэх хэсэг

² СЗХ-ны Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам (СЗХ-2020/09/09 #880)-ын 3.1 дэх хэсэг

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР №2

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн
Р-2026-21 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт



КУМУЛЯТИВ АРГААР ӨГӨХ САНАЛ ХУРААЛТЫН ХУУДАС

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Тайлбар/Санамж:

Таны өгөх нийт саналын тоо нь бүртгэлийн өдрөөр таны эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-ийн нийт гишүүдийн тоо¹ буюу Банкны Дүрмийн дагуу 12-оор үржүүлж тооцогдоно. ТУЗ-ийн 12 гишүүний 8 нь ердийн, 4 нь хараат бус гишүүдээс бүрдэнэ.

Томьёо:

$$\text{Саналын эрхийн тоо} = \text{Бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй таны хувьцааны тоо} \times 12$$

Хувьцаа эзэмшигч нь саналаа ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх боломжтой. Энэхүү арга нь хувьцаа эзэмшигч өөрийн хүсэл зоригоор нэг эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид саналаа төвлөрүүлэн өгөх боломжийг олгодог.² Санал хураалтын үр дүнд хамгийн олон санал авсан нэр дэвшигчид нь ТУЗ-ийн гишүүдээр сонгогдоно. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолно. Энэ нь ердийн гишүүнд нэр дэвшигчдийг хооронд нь жагсаан, эрэмбэлэх арга бөгөөд хамгийн олон санал авсан найман нэр дэвшигч ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдоно. Үүний адилаар, хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг мөн хооронд нь жагсаан эрэмбэлж, хамгийн олон санал авсан дөрвөн нэр дэвшигч ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдоно.

Саналаа хуваарилан өгөх жишээ:

Хувьцаа эзэмшигч А нь ХҮ ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 12 гишүүнтэй, үүнээс 4 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ.

¹ Компанийн тухай хуулийн 72.1.3 дахь заалт; СЗХ-ны Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам (СЗХ-2020/09/09 #880)-ын 2.1 дэх хэсэг

² СЗХ-ны Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам (СЗХ-2020/09/09 #880)-ын 3.1 дэх хэсэг

Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 1200 саналтай болно. Тэрээр дараах байдлаар саналаа хуваарилан өгөх боломжтой:

- Нийт 1200 саналаа бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэр дэвшигчид өгөх; эсхүл
- Нийт 1200 саналын 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 8 хүртэл нэр дэвшигчид, үлдсэн 600 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 4 хүртэл нэр дэвшигчид тус тус өгөх; эсхүл
- Өөрийн нийт саналыг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

САНУУЛГА: Өөрийн саналыг хэрхэн хуваарилан өгөхөөс үл шалтгаалан, таны өгөх нийт саналын тоо нь дээр дурдсан Томьёоны дагуу тодорхойлсон саналын эрхийн тоотой тэнцүү байх шаардлагатай. Хэрэв таны өгсөн саналын тоо нь таны саналын эрхийн тооноос илүү байх тохиолдолд таны санал хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
ТУЗ-ийн ердийн гишүүнд		
1.	Ашот Осипян	
2.	Баатарын Батсайхан	
3.	Мелисса Мой Тиен	
4.	Майкл Мадден	
5.	Санжай Гүпта	
6.	Сюзанна Карр	
7.	Нямтайширын Цэлмүүн	
8.	Гүмэнжавын Цэвэгжав	
ТУЗ-ийн хараат бус гишүүнд		
1.	Эми Чой (Лай Фунг Чой)	
2.	Брэд Жонс	
3.	Нираж Вэдва	
4.	Эрэндоогийн Оюунбилэг	
5.	Стюарт Доналд Холл	

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн (үнэт цаасны компани) _____

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал: _____

_____ / _____

2026 оны ... сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналаа заасан хугацаанд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр урьдчилан өгөх боломжтой.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд санал хүчинтэйд тооцогдоно.
3. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол санал хүчингүйд тооцогдоно.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудасны хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй / Хүчингүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл, хэрэв бий бол: _____

